# ЗАСГИЙН ГАЗРААС ХӨГЖҮҮЛЭХ ТУСГАЙ СОНИРХЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН НЭР ТӨРӨЛ, БҮТЭЭГДЭХҮҮН, ЧИГЛЭЛИЙГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА, ТӨЛӨВЛӨЛТ

*2 0 1 2 - 2 0 1 6*

- Макро орчны шинжилгээ
- Микро орчны шинжилгээ
- Дотоод орчны шинжилгээ
- CROSS SWOT шинжилгээ
- Стратеги төлөвлөлт

**Улаанбаатар хот**

2012 оны 11 дүгээр сар

# СУДАЛГАА, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАГИЙН ТАНИЛЦУУЛГА:

Төслийн удирдагч: М.Ганхуяг
*“Найчрал Састайнэблэ” ХХК-ийн захирал*

Төслийн багийн ахлагч: Ц.Өнөржаргал
*Аялал жуулчлалын тэргүүний ажилтан,*
*Удирдлагын Академийн ахлах багш*

Зөвлөх багийн гишүүд: Ө.Амгалан
*Аялал жуулчлалын тэргүүний ажилтан,*
*МУБИС-ийн түүх аялал жуулчлалын тэнхимийн эрхлэгч*

В.Мөнхбаяр
*Аялал жуулчлалын тэргүүний ажилтан,*
*“Идэр” ДС-ийн аялал жуулчлалын тэнхимийн эрхлэгч*

Г.Цогбадрал
*Аялал жуулчлалын тэргүүний ажилтан,*
*МУБИС-ийн байгалийн аялал жуулчлалын тэнхимийн багш*

М.Амаржаргал
*Аялал жуулчлалын тэргүүний ажилтан, МУИС-ийн Газар зүй-Геологийн сургуулийн аялал жуулчлалын тэнхимийн багш*

*Ө.Ганпүрэв*
*Аялал жуулчлалын тэргүүний ажилтан,*
*Төслийн Удирдлага, хөгжлийн хүрээлэнгийн төлөвлөлтийн албаны дарга*

*Б.Пүрэвсүрэн*
*Төслийн Удирдлага, хөгжлийн хүрээлэнгийн сургалтын албаны дарга*

Ё.Батсүх
*Удирдлагын Академийн ахлах багш*

## АГУУЛГА

1. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН МАКРО ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

2. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН МИКРО ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

3. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН ДОТООД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

4. ОРЧНЫ СУДАЛГААНЫ НЭГДСЭН ДҮГНЭЛТ ШИНЖИЛГЭЭ

5. ТУСГАЙ СОНИРХЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТӨЛӨВЛӨЛТ

## УДИРТГАЛ

Энэхүү судалгааны зорилго нь тус салбарын  өнөөгийн нөхцөл байдалд шинжилгээ хийх, тусгай сонирхлын аялал жуулчлалын нэр төрөл, бүтээгдэхүүн, чиглэлийг тогтоож, тогтвортой хөгжилд суурилсан менежментийг сайжруулах арга замыг тодорхойлоход оршсон болно.

Судалгаагаар аялал жуулчлалын салбарт шууд ба шууд бус нөлөөлөх микро макро орчны шинжилгээ хийх, дотоод орчны судалгааг гүйцэтгэж, менежментийн чадамжийн шинжилгээ хийх, орчны нөхцөл байдалд үнэлгээ өгч боломж, бэрхшээл, давуу болон сул талуудыг тодорхойлох, нөлөөллийг тодорхойлсны үндсэн дээр нэгдсэн дүгнэлт гаргаж, шийдлийг тодорхойлох зэрэг зорилтуудыг дэвшүүлэн ажилласан. Аялал жуулчлалын салбарын  тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд шаардлагатай орчны суурь судалгаанд баримтын судалгаа, асуумж судалгаа, асуудал шалтгааны шинжилгээ, мексоны шинжилгээ, чадамжийн индексийн шинжилгээ, экспертийн шинжилгээ, SWOT  шинжилгээ, Нөлөөллийн үнэлгээний арга, CROSS SWOT шинжилгээ, Эрсдлийн нөлөөллийн шинжилгээ зэргийг  ашиглаж ò¿¿âýð ñóäàëãàà, àжиглалт судалгаа áîëîí õàðüöóóëàí æèøèõ, задлан шинжлэх, íýãòãýí ä¿ãíýõ àðãóóäûã õýðýãëýëýý.

Аялал жуулчлалын салбарт тусгай сонирхлын аялалыг хөгжүүлэх судалгааны ажил нь гадаад орчны макро, микро орчин болон дотоод орчин, нэгтгэл, төлөвлөлт  гэсэн 4 бүлгээс бүрдсэн.

Цаашид тус  салбарыг хөгжүүлэхэд хамтран ажиллагч талуудын идэвхтэй хамтын ажиллагаа нэн чухал байна. Түүнчлэн тусгай сонирхолын аялалыг хөгжүүлэх удирдлагыг иж бүрэн, тогтвортой  хэрэгжүүлж, орчны судалгаанд дурьдагдсан  давуу талууддаа түшиглэн бэрхшээлийг даван туулж,  сул талаа арилгаж ажиллах тал дээр анхаарлаа хандуулах нь зүйтэй юм.  Энэхүү судалгааны баримт бичиг нь аялал жуулчлалын талаар төрөөс баримтлах бодлогын үр нөлөөг дээшлүүлэх, урт, дунд, богино хугацааны шийдвэр гаргахад тодорхой хувь нэмэр болно гэдэгт судлаачдын зүгээс итгэлтэй байна.

Бүсүүдийн аялал жуулчлалыг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулах  ажлын хэсэг

2012.12.05

# НЭГ. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БҮСҮҮДЭД ТУСГАЙ СОНИРХЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ МАКРО ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

## 1.1 Тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх улс төрийн орчны боломж

### *1.1.1 Үндэсний хөгжлийн цогц бодлого*[1]

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын зорилтод аÿëàë æóóë÷ëàëûã ýð÷èìòýé õºãæ¿¿ëæ, ýäèéí çàñãèéí òýðã¿¿ëýõ ñàëáàðûí íýã áîëãîîî хэмээн заасан байна. Тус төлөвлөгөөнд “Æóóë÷èí òýýâýðëýõ áîëîí æóóë÷èí õ¿ëýýí àâàõ õ¿÷èí ÷àäëûã íýìýãä¿¿ëæ, àÿëàë æóóë÷ëàëûí ãîë á¿ñ íóòãèéí çàì õàðèëöàà, õîëáîî, ýð÷èì õ¿÷íèé õàíãàìæèéã ñàéæðóóëж, àÿëàë æóóë÷ëàëûí ãîëëîõ çàõ çýýëèéí îðíóóäàä õèéõ øóóä íèñëýãèéí òîîã íýìýãä¿¿ëæ, øèíý ÷èãëýë¿¿ä íýýõ” гэж тусгасан нь тусгай сонирхлын аялалыг хөгжүүлэхэд ихээхэн түлхэц болох юм. Үндэсний хөгжлийн цогц бодлогын зорилтод Àÿëàë æóóë÷ëàëûí òîìîîõîí öîãöîëáîðóóäûã áàðüæ áàéãóóëàí, àÿëàã÷, æóóë÷äûí ñîíèðõëûã òàòñàí àÿëëûí òºðë¿¿äèéã á¿ñ íóòààð òºðºëæ¿¿ëýí õºãæ¿¿ëýх зорилт дэвшүүлсэн байна. Тус төлөвлөгөөний томоохон зорилтуудын нэг нь óëèðëûí õàìààðëûã áàãàñãàæ, á¿òýýãäýõ¿¿í, ¿éë÷èëãýýíèé íýð òºðëèéã îëøðóóëàõ зорилт юм. Мөн аялал жуулчлалын ñàëáàðûí áîäëîãûã õýðýãæ¿¿ëýõ ÷èã ¿¿ðýã á¿õèé á¿òýö áèé áîëãîæ àæèëëóóëснаар ìîíãîë èðýõ æóóë÷äûí òîîã õ¿í àìûí òîîòîé òýíöýõ¿éö áîëãîõ зорилт дэвшүүлсэн байна.

### *1.1.2 Шинэчлэлийн засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр*[2]

Ардчилал, ХҮНИЙ эрх, эрх чөлөө, монгол эх орныхоо хөгжил цэцэглэлтийн төлөө нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт хийх шинэчлэлийн үзэл санаанд нэгдэн Ардчилсан нам, иргэний зориг ногоон нам, махн-муан-ын “шударга ёс” эвсэл хамтран: Үндэсний эрх ашгийг дээдлэн, хувь хүн, өрх гэрийн хөгжлийг эрхэмлэж, баялгийг бүтээгч, чинээлэг, эрх чөлөөт иргэдийн хариуцлагатай нийгмийг төлөвшүүлэх эрхэм зорилгоо нотлон, Хүний жам ёсны, заяагдмал эрх, хувийн өмч, төрийн хязгаарлагдмал оролцоо, төрийн нээлттэй, иргэдэд хянагдах тогтолцоо иргэний нээлттэй нийгэм, жендерийн тэгш байдал зэрэг тулгуур үнэт зүйлсийг шалгуур болгон, Монгол төрийн бодлогын залгамж чанарыг эрхэмлэн, Сонгуулийн шинэ хуулиар тогтоосон хязгаарлалт, хэм хэмжээг мөрдлөг болгон, Нам, эвслийн гишүүд, дэмжигчид, олон нийтийн нэмэрлэсэн санаа, санал санаачлагад тулгуурлан, Эдийн засгийн аюулгүй байдал, ардчилсан засгийн шударга тогтолцоог хангах, баялгийн шударга хуваарилалтанд түлхүү анхаарах цаг ирснийг тунхаглан, АН-ын “Монгол хүн” хөтөлбөрийг үндэслэн, ИЗНН-ын “Амьдрал” хөтөлбөр, МАХН-МУАН-ын “Шударга ёс” эвслийн “Монголоо аврах таван хувьсгал” хөтөлбөрийн зарим тодорхой саналуудыг тусган дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна. Шинэчлэлийн Засгийн газраас аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааны талаар хөтөлбөртөө тусгасан бөгөөд дараахь бодлого, шинэчлэлийг Засгийн газраас авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- ✓ Гадаад, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд шаардлагатай дэд бүтцийг бий болгоно.
- ✓ Монгол Улс руу чиглэсэн олон улсын нислэгийн давтамж, чиглэлийг хоёр дахин нэмэгдүүлнэ.
- ✓ Говийн аялал жуулчлалын бүс, Орхоны хөндийн аялал жуучлалын бүс, Хөвсгөл нуурын аялал жуулчлалын бүсийг холбосон дэд бүтэц байгуулна.
- ✓ Орхоны хөндийн аялал жуулчлалын бүсийг хөгжүүлж Хархоринг байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалын хот болгон хөгжүүлнэ.

---

[1] БШУЯ. http://www.mecs.gov.mn/article-120-444.mw. 2012 оны 11 дугаар сар 4

[2] Шинэчлэлийн Засгийн Газрын албан ёсны веб сайт. http://www.open-government.mn/. 2012 оны 11 дугаар сар 4

- ✓ Аймаг, бүс нутгийн онцлогт тулгуурласан аялал жуулчлалын хөтөлбөр хөгжүүлнэ.
- ✓ Монгол ахуй, соёлыг гадаад улсад сурталчлах цогц хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- ✓ Үлэг гүрвэлийн музей, парк, палентологийн лабораторийг улсын төсвөөр байгуулна.
- ✓ Бүх аймгуудад орон нутгийн уран зураг, гар урлал, фото зургийн галерей байгуулахыг дэмжинэ.

*Үйлчилгээний бизнесийг дэмжих чиглэлээр:*

- ✓ Найдвартай, аюулгүй, мэдлэг, ур чадварт суурилсан үйлчилгээний салбартай улс орон болно.
- ✓ Үйлчилгээний салбарын мэргэжлийн холбоодын үйл ажиллагааг онцгойлон дэмжинэ.
- ✓ Үйлчилгээний салбарын мэргэжлийн холбоодод тус салбарын хэмжээнд мөрдөх стандарт, ёс зүйн дүрэм, үйлчилгээний зэрэглэл, тарифын зохицуулалтыг батлах эрх олгоно.
- ✓ Такси, зочид буудал, зоогийн газар болон бусад үйлчилгээний ажилтанд англи хэл сургах хөтөлбөр хэрэгжүүлнэ.

*Эдийн засгийн хөгжлийг хангах, тогтвортой өсөлтийг дэмжих чиглэлээр:*

1. Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчилж, аж үйлдвэрийн болон экологийн тэргүүлэх хөгжлийн бүсүүдийг тогтооно.
2. Бүсийн дагуух үндсэн дэд бүтцийг байгуулж, эдийн засгийн болон ажиллах хүчний хязгаарлагдмал нөөцийг тулгуур хотуудад байршуулах замаар хөгжих бодлогыг тодорхойлно.
3. УИХ-аас баталсан "Шинэ бүтээн байгуулалт" хөтөлбөр, Төмөр замын талаар баримтлах төрийн бодлогод тусгагдсан төмөр замыг хөтөлбөр, бодлогод тусгасан үе шатын дагуу барьж байгуулна.
4. Аймгийн төвүүдийг Улаанбаатар хоттой болон ойролцоох хилийн боомттой хатуу хучилттай авто замаар холбоно.
5. Транзит тээврийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн хурдны зам барьж ашиглалтад оруулна.
6. АН-4 Улаанбайшинт-Өлгий-Ховд-Ярант, Ховд-Улаангом чиглэлийн авто замыг ашиглалтад оруулна.
7. Далайд гарцгүй орны хувьд агаарын харилцааг эдийн засгийн тэргүүлэх чиглэлд тооцон төрийн бодлогоор дэмжин хөгжүүлнэ.
8. Хөшигтийн хөндийд шинээр баригдах олон улсын нисэх онгоцны буудлыг олон улсын зорчигч болон ачаа тээврийн өрсөлдөх чадвар бүхий төв болгоно.
9. Агаарын тээврийн салбарыг чөлөөлөх бодлогыг 2016 он хүртэл үе шаттайгаар хэрэгжүүлж, төр-хувийн хэвшлийн түншлэлийг дэмжинэ.
10. "Шинэ Улаанбаатар" төслийн хүрээнд хот төлөвлөлтийг шинээр хийж, нэгдсэн бодлогоор инженерийн дэд бүтцийг байгуулан, Улаанбаатар хотод 17 иж бүрэн хорооллыг барьж байгуулна.

*Соёл урлагийг дэмжих чиглэлээр:*

- ✓ Аймгийн төв бүрт кино театр, фитнес төв, усан бассейн бүхий залуучуудын соёлын ордон байгуулна.
- ✓ Соёл урлагийн салбарт өмчийн олон хэлбэр, зах зээлийн шударга, чөлөөт өрсөлдөөнийг бий болгож, төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжин хөгжүүлж, соёлын үйл ажиллагаанд гэр бүл, иргэдийн тэгш оролцоог хангана.
- ✓ Соёлын үнэт зүйлсийг бүтээн туурвигч, соёлын үнэт биет бус өвийг өвлөн уламжлагчийг төрийн анхаарал халамжид байлгана.
- ✓ Соёлын байгууллагын барилга байгууламжийн стандартыг бий болгож шаардлагатай музей, театрын барилгыг шинэчлэнэ.

- ✓ Түүх, палентологи, археологийн олдворыг нэгдсэн бүртгэлд оруулж, хадгалж хамгаалах хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг соёлын үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах, тэдний авъяас, хөдөлмөр бүтээлийг дэмжинэ.
- ✓ "Монгол хүн" бэлтгэдэг бага ангийн тогтолцоог бүрдүүлж хүүхдийг эх хэл, бичиг үсэг, түүхээ бүрэн төгс эзэмших, үндэсний соёлын мэдрэмж, мэдлэг, хүмүүжилтэй болгох ажлыг хийнэ.
- ✓ Дэлхийн Монгол соёл судлалын төвийг байгуулж, үйл ажиллагааг нь төрөөс тусгайлан дэмжинэ.

*Байгаль, экологийн чиглэлээр:*

- ✓ Томоохон гол мөрнүүдэд урсацын тохиргоо хийх замаар усны сан байгуулж бүс нутгийн усны хэрэгцээг хангана. Хөв цөөрмүүдийг аймаг бүрт байгуулна.
- ✓ Гол мөрний урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад хамруулж, гол усыг эзэнтэй болгоно.
- ✓ Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлнэ.
- ✓ Ойг түймэр, хөнөөлт шавьж, өвчин, хууль бус мод бэлтгэлээс хамгаалах ажлыг эрчимжүүлж, ойг зүй зохистой ашиглах, мод орлох технологийг нэвтрүүлнэ.
- ✓ Устах аюулд орж байгаа амьтан, ургамлаа хамгаалах, уугуул нутагт нь сэргээх, тарималжуулах ажлыг эрчимжүүлнэ.
- ✓ Дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, нөхөн сэргээлтийн хөрөнгийн баталгаа гаргадаг тогтолцоог бий болгоно.
- ✓ Уул уурхайн нөхөн сэргээлтэд "дүйцүүлэн хамгаалах" механизмыг нэвтрүүлнэ.
- ✓ Байгаль орчинд хохирол учруулсан талаар бодитой мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулдаг тогтолцоог бүрдүүлнэ.

*Гадаад бодлогын чиглэлээр:*

- ✓ Европын Холбооны нийтлэг зарчим, хэм хэмжээ, стандартыг Монгол Улсад нэвтрүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- ✓ Монгол Улсын иргэдийн гадаадад зорчих нөхцлийг хөнгөвчлөх, гадаадад байгаа Монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах, "Иргэдэд туслах сан"-гийн үйл ажиллагааг өргөжүүлэх, консулын үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй болгох ажлыг зохион байгуулна.
- ✓ Монгол Улсын хөгжил, үндэсний хэл, соёл, өв уламжлалыг дэлхий нийтэд сурталчлан таниулах, Монгол судлалыг дэмжиж ажлыг эрчимжүүлнэ.
- ✓ Монгол иргэд ихээр зорчдог ОХУ, БНСУ, Япон, АНУ, Европын холбооны орнуудад зорчих визний нөхцлийг хөнгөвчилнө.
- ✓ Хил орчмын худалдааг дэмжиж, орон нутгийн иргэдийн түр хугацаагаар хил нэвтрэх боломжийг сайжруулна.

### *1.1.3 Хөгжлийн бодлого, хөтөлбөрүүд*

*Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд* 2010 оноос хойшхи 10 жилд бүсүүдийн хүрээнд бий болсон бүс нутаг хот байгуулалтын нэгдмэл тогтолцоо, бүс хоорондын болон улс хоорондын аж ахуйн хоршилт, дэд бүтцийн сүлжээнд үндэслэн аймаг, бүс нутгийн аж ахуйн бие даасан байдлыг дээшлүүлэх, бүс нутгийн эдийн засаг, нийгмийн тэнцвэрт хөгжлийг хангах, улмаар үндэсний эдийн засаг, нийгмийн дэвшлийг түргэтгэх нутаг дэвсгэрийн бүтэц, зохион байгуулалтын дотоод, гадаад таатай орчин бүрдэж эхэлнэ” гэж дурджээ Ìîíãîë óëñûí 21 ä¿ãýýð çóóíû Òîãòâîðòîé õºãæëèéí õºòºëáºðèéã 1994–1998 îíä áîëîâñðóóëæ Ìîíãîë Óëñûí Çàñãèéí ãàçðààñ 1998 îíû 5 äóãààð ñàðä áàòàëñàí.[3]




**Тогтвортой хөгжлийн стратегийн хэрэгжилт**

| | | Нийгмийн хөгжил | Байгаль орчин | Эдийн засаг | Хэрэгжүүлэх арга хэрэгсэл | Нийт |
|---|---|---|---|---|---|---|
| Тогтвортой хөгжлийн үндэсний стратегийн зорилтын тоо | | 17 | 13 | 15 | 14 | 59 |
| 2006 оны байдлаар ТХ-ийн стратегийн зорилтыг хэрэгжүүлж байсан үзүүлэлт. | | 9 | 3 | - | 1 | 13 |
| 2012 оны байдлаар тусган хэрэгжүүлж байгаа зорилт: | | 23 | 9 | 39 | 9 | 80 |
| Үүнээс: | Засгийн газрын мөрийн хөтөлбөр, /2008-2012 он/ | 10 | 5 | 20 | 5 | 40 |
| Үүнээс: | Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод тулгуурласан үндэсний цогц бодлогын зорилтууд | 6 | 2 | 13 | 2 | 23 |
| Үүнээс: | Монгол Улсыг хөгжүүлэх нийгэм, эдийн засгийн үндсэн чиглэл /2011 он/ | 7 | 2 | 6 | 2 | 17 |

Çàì òýýâýð, áàðèëãà, õîò áàéãóóëàëò, íèéòèéí àæ àõóéí ñàëáàðûí ò¿âøèíä 2006 îíä òîãòâîðòîé õºãæëèéí ¿íäýñíèé ñòðàòåãèéí íèéò 59 çîðèëòûí 14 àðãà õýìæýý õýðýãæèæ áàéñàí áîë 2012 îíû áàéäëààð íèéò 80 àðãà õýìæýýã õýðýãæ¿¿ëæ áàéíà. ¯¿íýýñ 40 àðãà õýìæýý 2008-2012 îíû Çàñãèéí ãàçðûí ìºðèéí õºòºëáºðò, 23 àðãà õýìæýý Ìÿíãàíû õºãæëèéí çîðèëòîä òóëãóóðëàñàí ¿íäýñíèé öîãö áîäëîãîä, 17 àðãà õýìæýý 2011 îíä Ìîíãîë Óëñûã õºãæ¿¿ëýõ íèéãýì, ýäèéí çàñãèéí ¿íäñýí ÷èãëýëä òóñ òóñ òóñãàãäàí õýðýãæèæ áàéíà.

- © “Á¿ñèéí òóëãóóð òºâ õîòóóä” хрөтөлбөр боловсруулагдсан (2003);
- © Ìîíãîë Óëñûí á¿ñ¿¿äèéí õºãæëèéí äóíä õóãàöààíû ñòðàòåãè боловсруулагдсан(2010);
- © “Òºðººñ òºìºð çàìûí òàëààð áàðèìòëàõ áîäëîãî” боловсруулагдсан (2010);
- © Ìÿíãàíû çàì áîëîí äýä á¿òöèéí áîññî òýíõëýã боловсруулагдсан (2001);
- © Óëñûí äýä á¿òöèéí ¿íäñýí òýíõëýã¿¿ä” боловсруулагдсан (2001)
- © “Óëñûí ãàçàð çîõèîí áàéãóóëàëòûí åðºíõèé òºëºâëºãºº” боловсруулагдсан  (2003)

## *1.1.4 Бүсчилсэн хөгжлийг дэмжих төрийн зохицуулалт*[4]

[3] http://www.undp.mn/publications/rio_report_mongolia.pdf
[4] Үйлдвэр, Хөдөө Аж Ахуйн Яамны адбан ёсны веб сайт. http://www.mofa.gov.mn. 2012 оны 11 сарын 4 нд үзэв.

Бүсчилсэн хөгжлийн чиглэлүүдийг нарийвчлан тогтоож бодлогод тусгах нь тусгай сонирхлын аялал жуулчлал болон гар урлал, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний маретингийг боловсронгуй болгох давуу талуудтай юм. Бүсчилсэн хөгжлийг төрөөс дэмжих бодлогын гол чиглэл нь Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот, тэдгээрийн орчмын нутгийн хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний хэт бөөгнөрөл, удирдлагын төвлөрөл, экологийн тэнцлийн алдагдлыг сааруулж, бүсүүдийн хөгжлийн түвшинг эрэмбэ дараатай дээшлүүлэх явдал юм. Бодлогын гол чиглэлийг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэглүүр болгон Монгол Улсад эдийн засгийн Баруун, Хангайн, Төвийн, Зүүн гэсэн дөрвөн бүсийг тогтоож, Улаанбаатар хотыг бие даасан бүсийн жишгээр хөгжүүлнэ. Монгол Улсын эдийн засгийн бүс бүрд хамаарах аймгуудын ерөнхий хуваарийг дараахь байдлаар тогтоож, хөгжлийн тухайн үеийн нөхцөл байдалтай уялдуулан уг хуваарийг уян хатан өөрчилж байна:

Баруун бүсэд: Баян-өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд;
Хангайн бүсэд: Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл;
Төвийн бүсэд: Говь-Сүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, өмнөговь, Сэлэнгэ, Төв;
Зүүн бүсэд: Дорнод, Сүхбаатар, Хэнтий.
Улаанбаатарын бүсэд: нийслэл хот, түүний дүүргүүдийн нутаг дэвсгэр, хот орчмын бүсийн дагуул хотууд тус тус орно.

Монгол Улсын аймгууд нь байгаль орчны даац, хүн, малын байршил, эдийн засаг, нийгмийн зорилтоороо харьцангуй ойролцоо шинж төлөвтэйг харгалзан эдийн засгийн бүсүүдэд аж ахуйн дараахь салбарыг нийтлэг байдлаар хөгжүүлнэ:

1. мал аж ахуй;
2. хөнгөн, хүнсний үйлдвэр;
3. уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр;
4. барилга, барилгын материалын үйлдвэр;
5. оюуны багтаамж ихтэй үйлдвэрлэл, үйлчилгээ;
6. аялал жуулчлал, амралт, рашаан сувилал;
7. үйлдвэрлэл, нийгмийн үйлчилгээний дэд бүтцийн салбарууд;
8. зах зээлийн дэд бүтцийн бүрдэл хэсгүүд.

Бүсүүдийн байгаль, түүхий эдийн нөөц, оюуны чадавхийг харгалзан баруун бүсэд: бэлчээрийн мал аж ахуй, усалгаатай тариалан, жижиг, дунд боловсруулах үйлдвэрийг; хангайн бүсэд: бэлчээрийн мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлал, амралт, сувилал, жижиг дунд үйлдвэр, уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр; мод боловсруулах үйлдвэрийг; төвийн бүсэд: бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр, жижиг, дунд үйлдвэр, аялал жуулчлал, амралт сувиллын үйлчилгээ, оюуны багтаамж ихтэй бусад үйлдвэрлэл, үйлчилгээг; зүүн бүсэд: уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр, эрчимжсэн газар тариалан, мал аж ахуй, жижиг, дунд үйлдвэр, аялал жуулчлалыг; Улаанбаатарын бүсэд: оюуны багтаамж ихтэй бүх төрлийн үйлдвэр, үйлчилгээ, олон улсын банк санхүүгийн сүлжээг тус тус тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлнэ гэж тусгасан нь аялал жуулчлалын бүсүүдийн төлөвлөлтөд тусгах хэрэгцээг бий болгож байна. Дэд бүтцийн босоо тэнхлэгүүдийг өмнөд- умардын, хэвтээ тэнхлэгийг өрнө-дорнын бүс нутгийн орнуудтай холбож олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлнэ гэж тусгасан нь иж бүрэн түншлэлийн механизмтай уялдаж байгаа юм.

### *1.1.5 Дэд бүтцийн хөгжлийн бодлого*[5]

[5] ГХГЗГ-ын албан ёсны веб сайт. http://www.gazar.gov.mn. 2012

Монгол Улсын нутгийн төв буюу төвийн бүсийн төвөөс зүүн тийш 400 орчим км зайтай нутгийн зүүн хагас дээгүүр дамжин өнгөрөхөөр Өмнөд, Умард хөршийн хооронд тавигдсан Говь-Гурван голын бүсийн босоо тэнхлэг, түүний төмөр зам дээр суурилсан улсын нийслэл болохынхоо хувьд цөөхөн хүн амынхаа хэрэгцээнд зориулсан үйлдвэр, аж ахуй, худалдаа, үйлчилгээ, эрүүл мэнд, соёл боловсролын байгууллагуудыг төвлөрүүлсэнээс Нийслэл Улаанбаатар хот өнөөгийн түвшинд хүрч алслагдсан болон говийн хүн амыг хөгжлөөрөө өөр үрүүгээ татах хүчтэй болжээ. Зах хязгаарын алслагдсан болон говь нутгаас зам, зах зээл, сургууль, эмнэлэг бараадан нийслэлийн зүг, төмөр замын дагуу чиглэсэн хүн амын шилжих хөдөлгөөн “Их нүүдэл”-ийн хэмжээнд хүрсээр 10 гаруй жил болж байна. Энэ бол Монгол улсын хувьд эмгэнэлтэй үр дагаварт хүргэх гажуудал юм. Монголын зах хязгаар нутгаар хүн ам сийрч Халх гол, Тамсагийн район бараг хүнгүй шахам болж Улаанбаатарын орчин Төв, Дархан, Сэлэнгийн нутгаар болон төмөр замын дагуух суурингуудад хүн амын нягтрал илүү байна.

Зураг. Монгол Улсын хүн амын нутагшлын тогтолцоо)




Монгол улсын хүн амын нутагшилтын мужлал

## Дэд бүтцийн тэнхлэг, түүнд тавигдах шаардлага

Гадаадын олон улсын хөгжлийн жишгийг харгалзсан ч, өөрийн улсын дотоод амьдралын хэрэгцээг үндэслэсэн ч Монгол Улсыг дэд бүтцийн тэнхлэгүүд дээр суурилуулан хөгжүүлэх бодлого баримтлах нь зүйтэй юм. Харин дэд бүтцийн тэнхлэгүүд нь Монгол Улсынх болохын хувьд дараах нөхцөлүүдийг хангаж байх шаардлагатай. Үүнд:

- Хүн амын нутагшиж суурьшсан нягтралыг баримжаалж байршуулах
- Төв суурингуудын амьдрал хөгжлийн суурь байхын дээр тэдний байршил өсөлтийг зохицуулах
- Нийгэм, экологийн баримжаалалтай эдийн засгийн суурь болох
- Нүүдэл, суурьшлын соёл иргэншлийн орон зайг зохистой хосолж бэлчээр хадгалж хамгаалах
- Хамгийн дөт бөгөөд саад багатай, үйлчилгээ сайтай байх
- Олон улсын болон тив хоорондын дэд бүтцийн сүлжээнд оновчтой холбогдох
- Нээлттэй бөгөөд дамжин өнгөрүүлэх (транзит) чадвар сайтай байх
- Гадаад далайд гарцтай болох
- Эдгээр шаардлага нь дэд бүтцийн ерөнхий чиглэл болон тэнхлэгийн шугам, сүлжээг байгуулахад баримтлах үндсэн зарчим болно.

- Дэд Бүтцийн үйлчилгээний сав нутаг ба Бүсчлэл Хангай, говийг хосолж байгаа нь бүсүүдэд амьдарлын адил тэнцүү орчин бүрдүүлэх урьдал нөхцөл болно.

Бүсүүдийн дэд бүтцийн босоо тэнхлэг,Улсийн дэд бүтцийн хэвтээ тэнхэлэгийн огтолцолд хамгийн ойр төв нь “Бүсийн хөгжлийн тулгуур төв хот болно” гэж үзээд: Их нууруудын хотгорт ХОВД, Хангай нурууны баруун талд УЛИАСТАЙ, Хангай нурууны зүүн талд ХАРХОРИН, Хэнтий нурууны баруун талд УЛААНБААТАР, дорнодын талд ЧОЙБАЛСАН хотыг Улсын Их Хурал Бүсийн хөгжлийн тулгуур төв хот болгон баталсан байна.



Зураг-7

Улсын Их Хурал бүсийн таван босоо тэнхлэгтэй байхаар хэлэлцэн баталсан боловч Алтай-Хөвсгөлийн бүсийг задалж Говь-алтай, Завхан аймгийг Баруун бүсэд, Хөвсгөл аймгийг Төвийн бүсэд оруулж нутаг дэвсгэрийн дөрвөн бүстэй болгон Улаанбаатар хотыг тусад нь биеэ даасан бүс болгож Эрдэнэт, Дархан, Зуунмод, Өндөрхаан хотуудыг мөн бүсийн хөгжлийн тулгуур төвүүдээр нэмж баталсан юм.

*Хөгжлийн стратегийн төв ба түүний байршил, нөхцөл*[6]

Монголын баруун хэсгийн хүн амын шилжих хөдөлгөөнийг тогтворжуулахын тулд Монгол нутгийн баруун хэсгийн буюу Баруун болон Алтай-Хөвсгөлийн бүсийн хүн амыг зах зээл, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээгээр өнөөгийн Улаанбаатар хоттой адил хангах үүрэгтэй хөгжлийн стратегийн төвийн байршлыг онож тогтоох явдал чухал юм. Энэхүү хөгжлийн стратегийн төв нь нутаг дэвсгэрийн геометрийн байгуулалтаар Хангайн нурууны баруун талд байрлах бөгөөд энэ хавийн газрын байдал, усны нөөцийг хот байгуулалтын даац талаас үзэхэд Завхан-Борхын голын бэлчир Далтын гарамын орчинд төвлөрөх нь хамгийн тохиромжтой юм. Завхан-Тээлийн голын бэлчир, Далтын гарамын орчинд хөгжлийн стратегийн төвийг байгуулахын тулд энэ орчныг дайрсан төмөр зам тавьж урагшаа Шивээ хүрэнгийн боомтоор Хятадын төмөр замтай, хойшоо Арц суурийн боомтоор Тывагийн нийслэл Кызыл (Төв Азийн төв цэг орщдог) хотыг дайран улмаар ОХУ-ын Абканы төмөр замтай нийлж Ази Европын төмөр замын олон улсын сүлжээнд холбогдох боломжтой. Энэ төмөр зам нь өмнөд Азийн орнуудыг Азийн хойт хэсэг болон Европ тивтэй хамгийн дөтөөр холбох юм.

Төв аймгийн төвийн дэргэд Хөшгийн хөндийн олон улсын нисэх нөөц буудал байгуулах нь Улаанбаатар хотын хөгжлийн татах хүчийг эрчимжүүлэн хүн амын төврүү чиглэсэн шилжих хөдөлгөөнийг улам нэмэгдүүлж манай өнөөгийн хамгийн тулгамдсан асуудлыг хурцатгах сөрөг үр дагавартай .

Монгол Улсын дэд бүтцийн хэвтээ тэнхлэгийн 400 кВ-ын цахилгаан дамжуулах шугам,

6 ГХГЗГ-ын албан ёсны веб сайт. http://www.gazar.gov.mn. 2012

өндөр хурдны мэдээлэл холбооны технологийн шугам Улиастай, Ховд хотуудын хооронд Улиастай-Борхын голын хөндийгөөр дамжуулан тавигдана. Мөн улсын дэд бүтцийн хэвтээ тэнхэлгийн автозам болох "Мянганы зам" хойгуур нь өнгөрнө. Улсын дэд бүтцийн хэвтээ тэнхлэгийн төмөр зам Монгол нутгийн баруун хэсгээр босоо чиглэлд дамжин өнгөрөх Төв Азийн төвийг дайрсан төмөр замтай хэсэг давхацаж байгаад Завхан-Борхын голын бэлчирт огтлолцоно. Завхан-Борхын голын бэлчирийн огтлолцлын орчимд төмөр замын олон улсын үйлчилгээний төв байгуулагдан түүнийг тойрсон төвлөрөл бий болж улмаар Донойн хөндийн олон улсын агаарын хөлгийн буудалтай холбогдоно. Энэ бүхний үр дүнд Завхан-Борхын голын бэлчирийн орчимд дэд бүтцийн шугамуудийн зангилаа үүсч төмөр зам, агаарын хөлгийн олон улсын үйлчилгээ төвлөрсөн хөгжлийн стратегийн шинэ Улиастай хот байгуулагдана. Ингэснээр Монголын баруун хэсгийн төдийгүй Орос, Хятад улсын хил орчмын муж районуудын гадаад харилцаанд ч нөлөөлөх ирээдүй бий.

Улаанбаатар хотын хөгжлийн эсрэг татах хүч бүхий болох Шинэ Улиастай хот Олон улсын чанартай дэд бүтцийн үйлчилгээний төвтэй, Улиастай-Борхын голоо даган 80 орчим км үргэлжлэн байгуулагдаж өнөөгийн тулгамдсан асуудал болох хүн амын шилжих хөдөлгөөн саармагжиж Их нүүдлийг зогсоон, Монгол Улсын нутагт адил тэнцүү амьдралын орчин бүрдүүлж улсын хөгжил тэгшрэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.

## *Бүсийн тулгуур төвүүдийг хөгжүүлэх дараалал*[7]

Бүсийн хөгжлийн тулгуур төвүүдээс Улиастайг хөгжлийн стратегийн төв-Шинэ Улиастай хот болгож түрүүлгүүлэн хөгжүүлэх явдал Монгол Улсын хөгжлийн шаардлагаас урган гарч байгаа юм.Цаашид Шинэ Улиастай болон Улаанбаатар хотуудын хөгжлийн таталцлын хооронд хоёр талын дэмжлэгтэйгээр Төвийн бүсийн тулгуур төв Шинэ Хархорин хот Орхон-Тамирын хөндийд байгуулагдана. Мөн дэд бүтцийн хэвтээ тэнхлэг, босоо тэнхлэгийн огтолцолд хамгийн ойрхон байрлалтай Баруун бүсийн хөгжлийн тулгуур төв Ховд хотын хөгжилд Орос, Хятадын хил залгаа муж, районы хоорондоо хамгийн дөт замаар шууд харилцах нийгэм эдийн засгийн сонирхол зэрэгээр нөлөөлнө. Зүүн бүсийн хөгжлийн тулгуур төв Чойбалсан хот ээнгүй шахам болсон зүүн хязгаарын Халх-Нөмрөгийн гол, Тамсагийн районыг эзэмшиж газар тариалан, мал аж ахуй эрхэлэх, Газрын тосны аж үйлдвэр хөгжүүлэх явдал тус бүсийн хөгжлийг дэмжинэ.

## 1.2 Аялал жуулчлалын салбарын хууль эрхзүйн орчин




Ìîíãîë óëñûí õýìæýýíä бàéãàëü îð÷èí, àÿëàë æóóë÷ëàëûí ÷èãëýëýýð 33 õóóëü, ¿íäýñíèé õýìæýýíèé 27 áîäëîãî õºòºëáºð õýðýãæèæ áàéíà.

***"Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль"*** хуулийн зорилт нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн тэнцлийг хангах үүднээс эдийн засгийг бүсчлэн

---

[7] ГХГЗГ-ын албан ёсны веб сайт. http://www.gazar.gov.mn. 2012

хөгжүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалттай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

***“Аялалын жуулчлалын тухай”*** хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аялал жуулчлалыг хөхүүлэн дэмжих, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх, жуулчны үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.
Аялал жуулчлалын тухай хууль тогтоомж нь Иргэний хууль, Газрын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль болон энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

***Тусгай хамгаалттай газар нутгийн тухай*** хуулийн зорилт нь байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх,соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсч өөрчлөгдөх зүй тогтлыг судлах,танин мэдэх зорилгоор газар нутгийг тусгай хамгаалалтад авах, ашиглах, түүний унаган төрхийг хадгалах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

***Бусад нийтлэг хуулиуд:***

- Иргэдэд зориулагдсан
- Аж ахуйн нэгж
- Төрийн байгууллага
- Төрийн бус байгууллага
- Салбарын хууль тогтоомжууд ба тушаал, шийдвэр, журам, стандарт зэрэг

## 1.2 Эдийн засгийн орчин

### *1.2.1 Монгол Улсын эдийн засгийн байдал, хандлага*




*Монгол улсын ýäèéí çàñàã ñýðãýæ çàì, òýýâðèéí ñ¿ëæýý, ¿éë÷èëãýýã ºðãºæ¿¿ëýí õºãæ¿¿ëýõ, áàðèëãà, õîò áàéãóóëàëò, ãàçðûí õàðèëöàà, íèéòèéí àæ àõóéí áîäëîãîíû ¿ð íºë°ºã äýýøë¿¿ëæ õ¿í àìûí àÿ òóõòàé, àþóëã¿é àìüäðàõ íºõöëèéã á¿ðä¿¿ëýõ боломж дээшилж байна.*[8]

Монгол улсын үйлдвэрлэдэг гол нэрийн бүтээгдэхүүнүүдийн гадаад болон дотоод эрэлт нэмэгдэж байгаа, аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ, тэр дундаа уул уурхай, олборлох салбарын хэмжээ тэлж байгаагаас тайлант оны эхний хагас жилийн байдлаар ДНБ-ий бодит хэмжээ (2005 оны сууръ үнээр) 2,152.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх 2010 оны мөн үеийнхээс 14.3 хувиар өсөлттэй гарлаа.
Харин оны үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 4,762.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх 2010 оныхоос 29.1 хувиар нэмэгджээ.
Энэхүү өндөр өсөлтөд аж үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын болон бүтээгдэхүүний татварын өсөлт голлон нөлөөлсөн. Уул уурхай, олборлолт аж үйлдвэрийн салбар 31 хувь өссөн нь аж үйлдвэр, барилгын салбарын нэмэгдэл өртөг оны үнээр 26.3 хувь, дотоодын худалдааны нийт борлуулалтын орлого өмнөх оны мөн үеийнхээс 36.3 хувь, тээврийн орлого 34.8 хувь өссөн нь үйлчилгээний салбар 25.5 хувь өсөхөд нөлөөлжээ.

Эдийн засгийн өсөлт 2013-2014 онуудад дунджаар 14.2-14.9 хувьтай байхаар байна. Энэ өсөлтөд уул уурхайн салбарт орж буй хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн боломжит хүчин чадлын хэмжээний өсөлт, экспортын бараа, бүтээгдэхүүний үнийн өөдрөг төсөөлөл нөлөөллөө.

ДНБ-ий бодит хэмжээ 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2013 онд 7207.8 тэрбум төгрөг, 2014 онд 8229.7 тэрбум төгрөгт хүрэхээр байна. Эдийн засгийн энэхүү өндөр өсөлтөд гадаадын хөрөнгө оруулагчид чухал үүрэгтэй. Монгол улсын зээлжих зэрэглэл 2010 оноос эхлэн сайжирч байна. Зээлжих зэрэглэл тогтоодог Фитч, Мүүдийз, Стандарт энд Пүүрс компаниуд Монгол улсын эдийн засгийг тогтвортой гэж үнэлсэн нь Монгол улсад орох гадны хөрөнгө оруулалтыг татах чухал үзүүлэлт болжээ.[9]

### *1.2.2 Аялал жуулчлалын салбарын эдийн засгийн асуудлууд*

[8] ҮНДЭСНИЙ ХӨГЖИЛ, ШИНЭТГЭЛИЙН ХОРОО-ны дарга Ч.ХАШЧУЛУУНЫ "Coal Mongolia 2012" чуулга уулзалтад тавьсан илтгэл. http://www.mining.mn/NewsDetails_7000.aspx
[9] СЯ-ны албан ёсны веб сайт. http://www.iltod.gov.mn/. 2012 оны 12 дугаар сар.




- Ìîíãîë Óëñ ç°âõ°í 2011 îíä 460.0 îð÷èì ìÿíãàí æóóë÷èí õ¿ëýýí àâ÷, àÿëàë æóóë÷ëàë äîòîîäûí íèéò á¿òýýãäýõ¿¿íèé 4.0 îð÷èì õóâèéã ýçëýõ áîëîâ. Ýíý ñàëáàðò 25.0 ìÿíãà îð÷èì àæëûí áàéð áèé áîëîâ.
- Дэлхийн аялал жуучлалын байгууллагын (UNWTO) мэдээгээр өнгөрсөн онд аялал жуулчлалын салбараас дэлхийн эдийн засагт 1,2 их наяд ам.доллар оруулжээ. Үүнээс 196 тэрбум нь зорчигч тээврийн үйлчилгээнээс олсон орлого гэнэ.
- Олон улсын аялал жуулчлал, зорчигч тээврийн салбар нь дэлхийн экспортын үйлчилгээний 30 хувийг эзэлж байна. Экспортын ангиллын хувьд жуулчлал нь түлш, химийн болон хүнсний бүтээгдэхүүний дараа дөрөвдүгээрт бичигдэж байгаа юм.
- Өнгөрсөн оны хувьд аялал жуулчлалын дэлхийн эдийн засагт оруулсан хамгийн их хувийг Европын орнууд (45%) оруулж, тэдний араас Ази, Номхон далайн бүс (28%) ба Америкийн бүс (19%) нэхэн явж байна.
- Европт жуулчид 463 тэрбум ам.доллар, Ази, Номхон далайн бүсийн орнуудад 289 тэрбум ам.доллар зарцуулжээ. Америкийн орнууд 199 тэрбум ам.долларыг жуулчдаас олсон байна.

Гэвч Монгол улс тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэхийн тулд хөрөнгө оруулалтын томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх шаардлага гарч байна.

### 1.2.3 Нөлөөлөх салбарын эдийн засгийн үзүүлэлтүүд

*Агаарын тээвэр*[10]



Шинэчлэлийн Засгийн газар зам тээврийн салбарыг хөгжлийн тэргүүлэх зорилтынхоо нэг болгон, тусад нь шинээр яам байгуулж, энэ салбарт тэргүүний техник технологитой улсуудын туршлагыг нэвтрүүлэхээр зорьж байгаа. Тиймээс Монгол Улсын Зам тээврийн яам улс орныхоо тээврийн салбарын бодлогыг зангидан, хөгжлийг нь тодорхойлж байдаг БНСУ-ын Тээврийн институтээс төлөөлөгчид урьж, хамтарсан семинарыг зохион байгуулан, тус улстай тээврийн салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан байна.

Манай улсын хувьд Төв Азийн чухал байршилд байдаг учир дамжин өнгөрөх тээвэрлэлт, зорчигч тээвэрлэлт нэмэгдсээр байгаа. "Чингис хаан" олон улсын нисэх буудал гэхэд л 2011 онд нэг сая зорчигч хүлээн авчээ. Мөн нисэх онгоцны шинэ буудал барих ажлыг эхлээд байгаагийн зэрэгцээ өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангахын тулд шинэ нисэх онгоцны буудал ашиглалтад орох хүртэл одоогийн "Чингис хаан" олон улсын нисэх буудлыг хэрхэн

[10] ИНЕГ. http://www.mcaa.gov.mn/news/show?id=1237. 2012 оны 12 дугаар сар

өргөтгөх, сайжруулах ажлын төлөвлөлөөг ч солонгос мэргэжилтнүүдтэй хамтран боловсруулах юм.

Санамж бичигт тусгаснаар талууд эхний ээлжинд тээврийн хөгжлийн асуудлаар хамтарсан судалгаа, шинжилгээ хийх, БНСУ-д ажилтнуудаа сургах ажлыг зохион байгуулахаар болжээ.

Дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын жишгээр зам тээврийн хөгжил нь улс орон, эдийн засгийн хөгжлөө авч явдаг. Хөгжлийн туршлагаасаа хуваалцаж буй БНСУ-д гэхэд 1971 оноос хурдны замыг далайцтай барьж эхэлсэн агаад түүнээс хойш өнөөдрийг хүртэл хугацаанд дотоодын нийт бүтээгдэхүүн нь 118 дахин өссөн байна. Мөн дэлхийн агаарын тээврийн эрчмийг судалж тооцон, аливаа улс орны нүүр царай болж байдаг нисэх буудалдаа томоохон хөрөнгө оруулалт хийн дэлхийд тэргүүлэх шинэ нисэх буудлыг барьж ашиглалтад оруулснаас хойшхи 10 жилийн хугацаанд олон улсын нислэг нь 60-70 хувь нэмэгдэж, эдүгээ дэлхийн 40 гаруй орнуудад нислэг үйлддэг, Зүүн хойд Азийн гол нисэх буудлын нэг болж чаджээ. Өнгөрсөн онд гэхэд л Инчоны олон улсын нисэх буудал 35 сая зорчигч хүлээн авсан байна.



Монгол Улсын агаарын тээврийн нийт зорчигч эргэлт 2010 онд 665,803 хүрсэн. Үүнээс олон улсын зорчигч эргэлт 529,000 байсан нь нийт эргэлтийн 79%, харин дотоодын зорчигч эргэлт 137,000 буюу 21%-ийг эзэлж байна. Зорчигч эргэлт дахин сэргэж эхэлсэн нь 2009 оноос 18%-аар өссөн дүн юм. Дотоодын зорчигч эргэлт сүүлийн арав гаруй жилийн хугацаанд тасралтгүй өөрчлөгдсөөр ирж, 2010 оны байдлаар дотоодын зорчигч эргэлт 2009 онтой харьцуулахад 55%-аар өссөн. МИАТ нь Монгол Улсын үндэсний агаарын тээвэрлэгч бөгөөд Улаанбаатар хотод төвтэй. 1954 онд байгуулагдсан тус компани Кореан Айр, Аэрофлот компаниудтай код харилцан эзэмших гэрээтэй. Тус компани дотоодын нислэг, мөн түүнчлэн Чингис хаан нисэх онгоцны буудал ба бусад орнуудын хооронд олон улсын нислэгээр үйлчилдэг. Олон улсын нислэгийг Москва, Берлин, Бээжин, Сөүл, Токио ба Улаанбаатар хотын хооронд үйлдэж байна. МИАТ нь дотоодын нислэгийн зах зээлд маш бага хувь эзэлж, дотоодын зорчигч тээвэр нь жил ирэх тутам багасч байна. Изинис Эйрвэйз 2006 онд байгуулагдсанаасаа хойш хуваарьт болон захиалгат нислэг үйлдэж байгаа бөгөөд дотоодын хамгийн том агаарын тээвэрлэгч юм. 2009 оны зунаас эхлэн Изинис Эйрвэйз нь БНХАУ-ын Хайлаар хот руу олон улсын нислэг үйлдэж эхэлсэн. Нэг жилийн дараа буюу 2010 оны зун ОХУ-ын Улаан-Үүд рүү олон улсын нислэг хийж эхэлжээ. Аэро Монголиа нь 2002 онд байгуулагдаж, дотоодын нислэгийг 12 чиглэлд, олон улсын нислэгийг 4 чиглэлд (ОХУ-ын Алтай, Иркутск ба БНХАУ-ын Урумчи, Хөх хот) үйлдэж байна. Чингис хаан нисэх буудлаас үйлддэг дотоодын томоохон чиглэлүүдэд Оюутолгой, Даланзадгад, Ховд, Тавантолгой, Овоот, Өлгий, Мөрөн, Улаангом багтдаг. МИАТ нь нийт зах зээлийн 50%-ийг эзэлж байхад бусад тээвэрлэгчид болох Изинис Эйрвэйз, Аэро Монголиа нь 2%-ийг эзэлж байна. Олон улсын нислэгийн үлдсэн хувийг Korean Air, Air China, Aeroflot, SCAT (Казакстан) зэрэг гадаадын тээвэрлэгчид гүйцэтгэж байна.

***Авто тээвэр*[11]**

[11] Монголын Авто замын Холбоо. http://www.mra.mn.




Монгол улсын авто замын сүлжээ бүрэлдэн бий болж судалгаа төлөвлөгөөний үндсэн дээр хөгжүүлэх боломж бүрдлээ. Авто замын сүлжээнд инженерийн хийц бүхий зам, замын байгууламж, хатуу хучилттай авто замын хэмжээ нэмэгдэж байна Хүн ард, зам хэрэглэгчдэд сайн чанарын авто замаар үйлчлэх боломж бий болж байна. Хатуу хучилттай авто замын хэмжээ нэмэгдсэнээр ТАЗ, ЗХЗ-ын хэмнэлт гарч өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ тариф буурах боломж бүрдэж байна. Ажлын байр нэмэгдэж, ядуурал болон хүн амын хэт төвлөрлийг бууруулахад чухал нөлөө үзүүлж байна.




Авто зам, замын байгууламж баригдсанаар олон салаа зам арилж тоосжилт багасан байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөл буурч байна. Сайн чанарын замын сүлжээг бүрдүүлсэнээр уул уурхай, аж үйлдвэрлэл зэрэг бусад салбар хөгжих дэд бүтэц бий болж улс орны эдийн засгийн өсөлтийг хурдасгахад нөлөөлж байна.

## *Төмөр замын тээвэр*[12]



[12] http://politics.time.mn/content/20604.shtml

“Төмөр замын тээврийн талаар төрөөс баримтлах бодлого”-ын эхний болон хоёр дахь шатны төмөр замын сууръ бүтцийг улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой хэмээн Засгийн газар үзэж байна. Монгол улсын төмөр замын сүлжээ нь 1, 815 км ба үүнээс 1,110 км Орос-Хятадыг холбосон гол зам /Транс-Монголын гол шугам/ бөгөөд 239 км нь Монгол Улсын зүүн хэсэг буюу Оросын төмөр зам руу салаалж баригдсан ба гол шугамнаас 477 км урт байгаа юм. Далайгаас алс хол Монгол улсын хувьд төмөр зам бол чухал ач холбогдолтой бөгөөд манай хоёр их хөршөөр дамжин Европ , Зүүн Ази, Зүүн өмнөд Азийг холбох шугам болж байгаа юм. 2004 оны 4 дүгээр сараас эхлэн Монгол-Хятад-Оросыг холбосон шилэн кабелийн сүлжээ барихаар болоод байна.  Цаашлаад уул уурхайн бүтээгдэхүүнийг олон улсын худалдаанд гаргахад чухал үүрэг гүйцэтгэх юм.  Монгол улсын Төмөр Замын байгууллага бол Төмөр замын хамтын ажиллагааны байгууллага, Олон улсын Транс-Сиберийн тээврийг зохицуулах байгууллагын гишүүн билээ.




## Нийгэм соёл, хүн ам зүйн орчин

### <u>*Түүхийн дурсгал*</u>

Монгол орон нь эртний хүний өлгий нутаг болох бөгөөд тус газар оршин суугчдын түрүү үеийн дурсгал 800000 жилийн тэртээ үе буюу хуучин чулуун зэвсгийн доод шатанд хамаарагддаг байна. Тийм дурсгал МУ-ын говь нутгаас арвин олддог. Монголын нутгаас хуучин чулуун зэвсгийн доод үе (2.5 саяас 300 мянган жилийн өмнөх үе хүртэл, зарим судлаач 100 жилийн өмнөх үе хүртэл гэх нь бий)-д хамаарах эртний хүний бууц Баянхонгор, Өмнөговь, Ховд, Дундговь, Дорноговь зэрэг аймгаас олдсон. Эдгээрээс Өмнөговь, Өвөрхангайн заагт байх Цахиуртын хөндийн суурing чухал ач холбогдолтой гэж үздэг. Учир нь суурингийн хамрах хүрээ нь нэлээд том 10 000 км.кв бөгөөд хуучин чулуун зэвсгээс гадна дунд болон шинэ чулуун зэвсгийн дурсгалууд газрын хөрсөн дээр нягт тархан хадгалагдан үлдсэн нь цаг хугацааны хувьд ийм урт хугацааг хамарсан дурсгал дэлхийд урьд өмнө олдож байгаагүй юм. (“флинтстоуныхан” гэдэг хүүхэлдэйг өөрийн эрхгүй санагдуулам) Мөн 800 000 жилийн өмнө хүн нутаглаж байсан Баянхонгорын Нарийн гол, Баянхонгорын Цагаан агуй, 300 000 мянганы тэртээх Дундговийн ярхийн суурин зэрэг нь мөн л чухал ач холбогдолтой дурсгалууд юм. Эндээс үзэхэд монгол нутагт даруй 800 000 жилийн тэртээд хүн нутаглаж байсан бөгөөд энэ үеийн Азид тархсан хүний зүйл нь х.эрэктус билээ. Тэр үед зануу, болоржин, хасын хольцтой шар хар цайвар цахиурлаг чулуулгаар хугадас зэвсэг, гурвалжин хэлбэрийн гилбэр мэс, хоёр талаас нь зассан үзүүр мэс зэргийг зонхилон үйлдэж байсан байна. 300 000-100 000 жилийн өмнөөс эхлэн хуучин чулуун зэвсгийн дунд үед

шилжиж чулуун зэвсгийн үйлдэх арга барил шинэ шатанд гарсан юм. Энэ үеийн дурсгалууд дээрхи аймгуудаас гадна Баян-Өлгий, Хэнтий зэрэг аймгийн нутгаас олддог. Энэ үеийн нэг ололт нь галыг дуртай үедээ гаргах болсон явдал байлаа. Мөн энэ үед байгаль цаг уурын өөрчлөлт ч гарч эхэлсэн үе юм. Энэ үе 50 000-30 000 жилийн өмнөх үе хүртэл үргэлжилжээ. Эндээс харахад х.эректус Монгол нутагт 800 000 мянганы тэртээгээс эхлэн 50 000-30 000 жилийн өмнөх үе хүртэл буюу хуучин чулуун зэвсгийн дунд үеийг дуустал оршин байж байгаад 100 000 жилийн тэртээх дөрөвдөгч галавын төгсгөлөөр үүссэн тивүүдийн шилжилт хөдөлгөөний улмаас үүссэн эх газрын өндөршилт, 70 000-ны тэртээ тохиолдсон Тобагийн сүйрэл зэргээс үүдсэн мөстлөг, хүйтрэл, 50 000-30 000 жилийн тэртээх шинэ чулуун зэвсгийг авчирсан хомо сапиенсийн Азийн гүн рүү орсон түрэлт зэргээс үүдэн мөхжээ гэж үздэг.




Монгол газар ангит нийгэм үүсэн, анхны төр улс Хүннү улсын цагт бий болж, XIII зууны үед монгол угсааны олон аймаг нэгдэж нэгэн гэр улс болсноор монгол угсаатан бүрэлдэн төлөвших эх үүсэл тавигджээ.

## ***Угсаатны зүй***

Хэлний хоёр бүлэгт багтах угсаатан ястан оршин суудаг. 90 гаруй хувийг монгол хэлний бүлэгт багтах халх, баяд, буриад, барга, дарьганга, дархад, дөрвөд, мянгад, захчин, өөлд, торгууд, үзэмчин, хамниган, харчин, хотгойд, цахар эзэлдэг. Хоёрдахь бүлэгт турк хэлтэн, казак, урианхай, хотон орно. Монгол улсын угсаатан ястангууд үндсэн хуулиар батлагдсан бүрэн эрх эдэлж, нийгэм улс төр, эдийн засаг, соёл боловсролын үйл хэрэгт адил тэгш эрхтэй оролцдог.




Алтайн Урианхай

Баруун Монголын нэгэн гол ястан нь Алтайн урианхайчууд болно. Эдний өвөг дээдэс нь Монгол нутгийн умард болон хойд захын ой хөвчөөр эрт дээр үеэс амьжиран сууж байсан ойн гөрөөчин аймаг юм.

Барга

Дорнод монголд суудаг нэг ястан нь Барга юм. Барга нарын эртний өвөг дээдэс нь XIII зуунаас урьд Байгал далайн тэндэх Баргажин төхөм гэдэг газар нутаглаж байсан баргуд хэмээх хүчирхэг аймаг болно.

Баоань

Мин улсын үед (Ванли хааны үед) Хөхнуурын Тунжэ сяньд Бао-ань гэдэг хуаран байгуулахад тус хот баригдан, улмаар тэнд төвлөн суудаг баоань ястан бүрэлдсэн байна.

Баяд

Монголын Баяд эртний өвөг дээдэс бол XII-XIII зууны үед Жида Баягуд Дуклас, Хээрийн Баягуд гэгдэж Баягуд аймгаас сурвалжтайн дээр Сэлэнгэ мөрний зүүнтэйх Зэд голоос урагш тал газар сууж агсан Жида Баягуд, Хээрийн Баягуд нь жинхэнэ монгол угсаатай гэж шинжээчид үздэг.

Буриад

Тэдний өвөг дээдэс нь Байгаль нуурын ар өврөөр нутаглаж асан эртний анчин гөрөөчин ойн иргэдийн нэгэн бөгөөд XIII зуунаас өмнөх үед Байгалаас хойш Хилого /хялго/, Зүлгэ /Лена/ мөрний сав, Сэлэнгийн адгаар сууж байсан Булгачин Хэрэмчин хийгээд Горлог /Енисей/ мөрний эхэн, Байгаль орчимд амьжирч агсан Хорь-Түмэд, Баргужин төхөмд аж төрөх Баргуд зэрэг монгол угсааны аймгууд байсан ажээ.

Дархад

Дархад бол монгол нутгийн умардад байсан ойн иргэдийн залгамчир болохын дээр анх монгол, түрэг овог аймгийн нийлбэрээс бүрэлдэн төлөвшсөн монгол угсаатан болно.

Дарьганга

Дарьгангачуул нь угтаа 1690-ээд оны сүүлчээр халх Монгол Манжийн захиргаанд орох үест Манжийн хааны төмөр сүргийг адуулгахаар цахар, халх, өөлдөөс татаж халхын Түшээт хан аймгийн говь Мэргэн вангийн хошуу, Сэцэн хан аймгийн хурц вангийн хошууны дунд суулгасан сүрэгчин хүмүүс болно.

Дээд Монголчууд

Дээд Монгол гэж Хөхнуурын газар нутаглах хошууд аймгийг хэлэх бөгөөд эдний өвөг дээдэс нь Ар монголоос тус газар нутагт шилжин нүүж очсон хүмүүс юм.

Дөрвөд

Дөрвөд бол эртний монгол угсаатан, ойн иргэдийн нэгэн. Ойрадын Зүүнгарын хаант улсын гол аймаг, Богд хаант монгол улсын үеийн Ховд хязгаарын зонхилох ястан юм.

Захчин

Захчин нь Ойрад Монголын нэгэн салбар бөгөөд Зүүн гарын хаант улсын үед тус улсын хил, зах хязгаарыг сахин хамгаалах цэргийн ард байсан учир захчин хэмээх нэрийг олжээ. Захчингууд нь торгууд, дөрвөд, өөлдөөс гаралтай яс овгоор бүрэлдсэн байна.

Казах Хасаг

Монгол Улсад оршин суудаг түрэг угсааны томоохон ястан нь казахууд билээ. Тэдний өвөг дээдэс нь МЭӨ I мянган жилийн дундуураас одоогийн Дундад Ази, Казахстаны нутагт орших байсан Сак хэмээх хүчирхэг аймаг болох бөгөөд түүний бүрэлдэхүүнд Маасагет, Дай, Каспий, Исседон болон хожим Алан, Савромат зэрэг овог аймаг оролцдог байжээ.

Монгор Ту

Монгол гаолын нэгэн угсаатан нь ту нар юм. Ту биеэ “Монгор” (Монгар) буюу “Цагаан монгол” гэдэг. Тэд удам судраа XIII зууны үед Чингисийн ургийн жанжин Гэртэй гэдэг хүн дагуулан ирснээс үүсэлтэй хэмээдэг.

Мянгад

Мянгад ястан нь Ховд аймгийн Мянгад сумын Нутаг Ховд голын адаг, Алтан Хөхий уулын орчмоор оршин суудаг 3000 эргэм хүн амтайн дээр Эрдэнэбүрэний Өөлд, Дөргөний дөрвөдтэй айлдан нутаглана.

Өөлд

Ойрад Монголын эртний сурвалжит нэгэн аймаг нь Өөлд болно. Өөлд гэдэг нэрийг ойрад (ойн ард) хэмээх үг сунжирснаар үүссэн гэлцдэг. Бас Илүдэй гэдэг хүний нэрнээс гаралтай ч гэдэг.

Синьцзяны Ойрадууд

Синьцзяны ойрадууд бол эртний дөрвөн ойрадын бүрэлдэхүүнд багтаж Эрчис, Алтай, Тарвагатай, Или, Өрөмчи зэрэг газраар нутаглаж байсан торгууд, хошуудууд болно.

Торгууд

Торгууд бол монголын их гүрний эзэн хааны торгон цэрэг болж явсан отог овгоос гаралтай, хожмын Дөрвөн Ойрадын улсын нэгэн гол аймаг юм.

Тува Урианхай

Алтайн урианхайчуудын дотор байдаг монголжсон түрэг урианхай нь тува урианхай болно. Тэдний үндсэн нутаг нь Алтай урианхайн Баруунгарын Шар Даа буюу Ёст гүний хошууны газар болох бөгөөд үүнийг бас мончоогийн хошуу ч гэдэг.

Үзэмчин

Дорнод монголд оршин суудаг өвөрлөгчдийн гаралтай ястан нь үзэмчин болно. Дорнод аймгийн Баянтүмэн, Сэргэлэн, Булган сумнаа зүүн үзэмчин, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумнаа баруун үзэмчнийнхэн нутаглана.

Халх

Халхчуудын өвөг дээдэс нь VIII-XII зууны үед Хэрлэн, Онон, Туул гурван голын саваар төвлөрөн нутаглаж байсан ба XIII зууны эхээр монголын нэгдсэн тулгар төр улс байгуулагдахад гол цөм нь болж тэргүүлэх үүрэг гүйцэтгэсэн ягуурын монгол аймгуудаар бүрэлдэн тогтсон.

Хамниган

Тус улсад оршин суудаг манж-түнгүүс угсаатан нь Хамнигад ястан болно. Эдгээр нь Сэлэнгэ зүгт Ерөө голын дагуу нутаглах Богд Жавзандамба хутагтын Их шавийн харъяат хамниган отгийнхон, Сэцэн хан аймгийн Дархан Ба гүн, Дайчин бэйс, Эрдэнэ гүн, Хөвчийн Жонон вангийн хошууны нутагт байдаг.

Хотогойд

Монголын умард болон баруун хойгуур Хөвсгөл, Завхан аймагт нутаглан суудаг халхжсан ойрадууд нь Хотогойд болно. Хотогойд гэдэг нэрийг "Хойд - Гойд" (хойд-онцгойд), "Хойд - Хойд"(умард хойд)"Хойд - Гайд" (гайд гарсан хойд)гэсэн үгнээс гаралтай гэж янз янзаар тайлбарладаг.

Хотон

Хотонгууд нь 200 гаруй жилийн тэртээгээс Дөрвөдүүдийн дотор хутгалдан суусаар ихэд монголжсон түрэг угсаатан юм.

Хөвсгөлийн Урианхай Ар Ширхтэн Урианхай

Урианхайчуудыг Хотогойдын ноёдын харъяат Ар ширхтэн отог гэж нэрлэхийн зэрэгцээгээр мөн ноёдын захиргаанд багтан, тэдэнд алба төлдөг Аригийн Урианхай нарыг Өвөр ширхтэн урианхай гэж ялган нэрлэжээ.

Цахар

Монгол улсын умард хил орчмоор суудаг, Нийслэл Хүрээнд түмний нэг нь Сэлэнгийн цахарууд болно. Эд нь угтаа Хятадын Синьжян мужид Илийн цахар хэмээх 16 сум болж Бор талаар нутаглаж байжээ.

Цаатан

Цаатан гэж Хөвсгөл аймгийн Улаан-Уул, Ринченлхүмбэ, Баянзүрх, Ханх зэрэг сумнаа нутагладаг тува угсааны монголжсон ойн соёд урианхайг хэлнэ.

## *Соёлын аялал жуулчлал*



Соёлын аялал жуулчлал улирал харгалзалгүй үйлчлэх боломж олгодог. Орчин үед дэлхий дахины хөгжлийн ерөнхий чиг хандлага нь зохистой хэрэглээ бүхий байгаль орчин, нийгэм, соёлд ээлтэй үйлдвэрлэлийг хөгжүүлэх, улс түмнүүд өөр өөрсдийн өвөрмөц онцлог шинж төрх, нөөц баялагаа хадгалах замаар улам бүр даяарчлагдах шинжтэй болж байна.

Соёлын аялал жуулчлалыг зөвхөн байгалийн болон соёлын нөөц баялагийг үзэж сонирхох төдийхнөөр хязгаарлах бус, тэдгээрийг хүлээн авч мэдэх, мэдрэх, түгээн дэлгэрүүлэх, хадгалж хамгаалах, аялал жуулчлалыг орчин үеийн дэлхий нийтийн стандартад нийцүүлэн зохион байгуулах үйл ажиллагааны арга технологийг багтаасан аялал жуулчлалын үйлдвэрлэл гэдэг өргөн утгаар ойлгох хандлагатай байна.[13] Соёлын аялал жуулчлал жуулчдад дахин ирэх сонирхолыг төрүүлэх, гүнзгий сэтгэгдэл үлдээх чадвар (олны танил болсон баяр наадам, фестиваль, үндэсний соёл урлагийн баялаг сан хөмрөг болон орчин үеийн жуулчны олон талт, өндөр эрэлт хэрэгцээнд нийцсэн үйлчилгээний чанар) сонирхлыг төрүүлдэг.

[13] Ж.Долгорсүрэн. "СОЁЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН УДИРДЛАГЫН ТЕХНОЛОГИ."http://guidemongolia.com/




*Буддын шашин.* Буддын гүн ухаан бүр Хүннүгийн үе буюу нийтийн тооллын өмнөх Монголд дэлгэрснээс хойш хөгжлийн 3 үе туулсан гэж үздэг. 17-р зууны үед амьдарч байсан Монголын Сүмбэ Хамба Ишбалжирын "Пагсам Чонсон" хэмээх бүтээл мөн Зава Дамдин гавжийн "Алтан Дэвтэр" хэмээх алдарт судруудад бичсэнээр энэ нь Буддизмын түрүү дэлгэрэлтийн үе гэж үздэг. Тухайлбал Нирун улсын үед Буддын шашин нь төрийн шашин байжээ.

Буддын шашны Монгол дахь дунд дэлгэрэлтийн үе буюу 13-14-р зууны үе, тухайлбал, Юань гүрний үед мөн төрийн шашны хэмжээнд хүрч тэр цагийн сор болсон Чойжи-Одсэр, Шаравсэнгэ тэргүүтэй нэрт эрдэмтэд төрөн гарч буддын гүн ухааны олон арван бүтээлээ туурвисан байдгаас "Буддизмын хос ёсны зарчим" хэмээх номлол нь тухайн үеийн монгол төрийн үндэс болж байсан байдаг.

Буддизмын хожуу дэлгэрэлтийн үе буюу 16-р зуунаас хойш үед Төвд орноос Зонхавын буюу шарын шашны хэлбэрээр орж ирсэн байна. 1570-аад онд Түмэдийн Алтан хан "Далай Лам" хэмээх цол буй болгон шарын шашныг төрийн шашин болгосноос хойш эдүгээ хүртэл 200 гаруй монголын сэтгэгчид Буддын гүн ухааныг судлан хөгжүүлж олон зуун судар ном туурвин бүтээжээ.[14]

Эрийн гурван наадам. Эрийн гурван наадам бөх, морь, сур гурвын үүсэл хөгжил олон зуун жилийн түүхтэй. Энэ олон жил монгол хүний сэтгэл зүйд хамгийн их тохирсон, илүү ойлгомжтой, сонирхол татдаг, шимтэн хардаг, таашаал авдаг, хүсэмжилдэг энгийн хэлбэр нь бөхчилсөн, амласан, эр бяраа гайхуулж ил тод өрсөлддөг, ялж ялагддаг энэ хэлбэр шалгарч үлдсэн. [15]Чингис хаан 1225 онд Сартуул улсыг дайлаар мордож ялаад цэрэг морьдоо амрааж их наадам хийх үеэр Есүнхэй мэргэн 335 алд газар харваж байгаа оносон түүх бий. Чингис хаан Есүнхэйн энэ амжилтад бахархаж 1226 онд Өргөнө мөрний хөндийд гэрэлт хөшөө босгосон нь “Чингисийн чулууны бичиг” хэмээн алдар¬шин түүхэнд үлдсэн юм. Өөрөөр хэл¬бэл нум суманд, харваачид төдийгүй спортын дээд амжилтад зориулж босгосон дэлхийн анхны хөшөө юм. Одоо ОХУ-ын Санкт-Петербургийн музейд байдаг юм. 335 алд нь одоогийн хэмжээсээр 502.5 метр болдог юм.

[14] http://www.buddhism.mn/
[15] Монголын Спортын Нэгдсэн сайт. http://www.sportnews.mn




***Спортын аялал жуулчлал***

Өнөөдөр спорт өндөр түвшинд хүрч хөгжсөн олонх улс орнуудад бүх шатны спортын байгууллага, клуб, холбоод спортыг аялал жуулчлалын бизнестэй холбон хөгжүүлж байна. Энэ нь спортыг олонд сурталчлах, тухайн байгууллагын үйл ажиллагааг хөхжүүлэн дэмжих, аялал жуулчлалаас олох ашиг орлогыг нэмэгдүүлэх, биеийн тамир, спортын хөгжлийг эрчимжүүлэх нэгэн арга зам юм. Олон улсад спортын аялал жуулчлал нь аялагчдынхаа хүсэл сонирхол, хэрэгцээ шаардлага, зорилгоос нь хамаарч идэвхтэй болон идэвхгүй гэсэн үндсэн хоёр хэлбэрээр хөгжиж аялал жуулчлалын үйлдвэрлэлд эзлэх орон зайгаа улам тэлсээр байна. Спортын ямарваа нэг тэмцээн уралдааныг үзэж сонирхох, хөгжөөн дэмжих, санамсаргүйгээр тохиолдох /Олимп, тив дэлхийн аварга шалгаруулах тэмцээн г.м/, улс үндэсний өвөрмөц спорт, соёлтой танилцах /Сумо, Тай бокс, Эрийн гурван наадам үзэх/спортын музей зэргийг үзэж сонирхох зэргээр спортын үйл явцад оролцож байгаag идэвхгүй спорт аялал/Passive sport tour/ гэж үздэг бол аялагч, жуулчид спортын аль нэгэн төрлөөр, тусгайлсан тоног хэрэгсэл ашиглан спортоор хичээллэх, аялах/төрөл бүрийн завь, дугуй, цанаар аялах г.м/, нэгдсэн зохион байгуулалттайгаар спортын арга хэмжээнд оролцох /Олимп, тив, вэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох/-ыг идэвхтэй спорт аялал/Active sport tour/ гэж үздэг. Техник, технологийн хөгжил, дэвшил, хүний хэрэгцээ шаардлага, хүсэл мөрөөдлөөс хамаарч аялагч, жуулчид спортын төрөл бүрийн тоног хэрэглэлийг ашиглан идэвхтэй байдлаар спортын аяллыг хийх нь ихсэж байна. Ийм зорилгоор хийгдэж буй аялал нь ихэндээ адал явдалт аялал жуулчлал/Adventure tourism/ болдог. Спортын аялал жуулчлалыг хөгжүүлэх нь тухайн улс орны спортын хөгжлийг хурдасгахаас гадна хүн амын эрүүл мэнд, бие бялдарын хөгжил, боловсролд сайнаар нөлөөлдөг.[16]

---

[16] *Д.Батболд. "СПОРТЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ". http://guidemongolia.com/*






Эх үүсвэр: http://www.mongolia-expeditions.com

***Нийтийн аялал жуулчлал***

Үйлдвэр, сургууль, албан газрын хамт олны дунд идэвхтэй амралт, аялал, экскурс, олон хоногийн тойрон аялал зохиох "Эрүүл агаар эм", "Алтан намар", "Цасан дээрх цэцэг" сэдэвт ажлууд, амралтын өдрүүдээр цана, тэшүүрийн бааз, байгалийн үзэмжит газруудаар аялах болжээ.



*Хотын аялал жуулчлал*

Хот суурины суурьшмал байдал нь аялал жуулчлал хийх, чөлөөт цаг өнгөрөөхөд дөхөм болдог бол нөгөө талаас хүмүүсийн аялал жуулчлал хийж, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх хэрэгцээ нь өөрөө хотын хөгжлийг шаарддаг байна




**Бүсүүдийн аялал жуулчлалын үл хөдлөх түүх соёлын дурсгалын төрөл**

*Чулуун зэвсгийн бууц, суурин, дархны газар*[17]

Чулуун зэвсгийн үе нь хүн төрөлхтний түүхийн хамгийн эртний бөгөөд хамгийн удаан үргэлжилсэн үе юм. Энэ үеийн хүмүүс хөдөлмөрийн багаж зэвсгээ гол төлөв чулуугаар хийж байсан учраас иймхүү чулуун зэвсгийн үе хэмээн нэрлэдэг.

Чулуун зэвсгийн үе нь палеолит (хуучин), мезолит (дунд), неолит (шинэ) хэмээх гурван үед хуваагдана. Палеолитийн үе нь монгол нутагт одоогоос 800 000 жилийн тэртээгээс эхэлж 12000 жил хүртэл үргэлжилжээ. Хуучин зэвсгийн дараагийн үеийг дундад чулуун зэвсгийн үе буюу мезолит (12000-7000 жил) гэж нэрлэдэг ба палеолитоос неолит буюу шинэ чулуун зэвсгийн үед шилжих шилжилтийн үе болно. Олон мянган жил үргэлжилсэн чулуун зэвсгийн төгсгөлийн томоохон үе бол неолит юм. Ойролцоогоор 7000 жилийн тэртээгээс 3000 жил хүртлэх үеийг хамарсан энэ үеийн хүний аж ахуйн гол шинж нь ан гөрөө хийх, ургамлын үр үндэс түүх зэрэг байгалийн бэлэн бүтээгдэхүүнийг шууд хэрэглэх нь хязгаарлагдаж мезолитын үед эхлэлийн төдий байсан аж ахуй ба өөрөөр хэлбэл газар тариалан, мал аж ахуй эрхлэх ажилд шилжсэн явдал юм.

Түүхэн хөгжлийн урт удаан хугацааны туршид эртний хүмүүс чулуун зэвсэг үйлдвэрлэх арга барил, хүрээлэн буй орчин, амьд байгалтай харьцах харьцаа, байгалын хатуу ширүүнд дасан зохицох, шинэ газар нутгийг эзэмших зэрэгт томоохон өөрчлөлт дэвшилт гаргасаар иржээ. Чухамхүү энэ үед л хүний эрт үеийн өвөг бүрэлдэн бий болж, хөгжиж, орчин үеийн арьстнууд үүсэн, дэлхийн бөмбөрцөгийн өнцөг булан бүрийн байгал цаг уурын таатай нөхцөл бүхий газар нутгийг эзэмших үйл явц явагджээ. Чухам чулуун зэвсгийн үеийн хүмүүс галыг гарган авч, зөв хэрэглэн сурч, хувцас зохион бүтээн, оромж сууц барих дадал зуршлыг эзэмшин, нум сумыг зохион бүтээж, ан агнуурын олон төрлийн зэвсэг багажийг хийж ашигладаг болсон байна.

Мезолитийн үед дэлхийн бөмбөрцөгийн хойд хэсэгт мөсөн бүрхүүл хайлж, байгал, цаг уур, хүрээлэн буй орчинд ихээхэн өөрчлөлт орж, хүн амьтны аль аль нь шилжин нүүх их хөдөлгөөнд орсон. Төв Ази, Монгол, Сибирийн нутагт арслан заан, савагт хирс мөхөн үгүй

[17] В.Мөнхбаяр. Докторын зэрэг горилох судалгааны ажил. 2012 он

болж, цаа бугын сүрэг хойд туйл руу нүүдэллэн оджээ. Умар зүг нүүдэллэж одсон амьтдын нүүдлийг дагаж хүмүүсийн их нүүдэл болж, Төв Азиас Умард Америк хүртэл хүн нүүдэллэн очиж суусан байна. Урьд нь палеолитийн үеийн анчид байгалын чулуу, мод болон бороохой, жад зэргийг ан агнуурт хэрэглэж байсан бол мезолитын үед модны уян хатан чанарыг мэдэж, ашиглан сэдэж хийсэн хамгийн анхны механик хүчийг ашигласан зэвсэг болох нум сумыг зохион бүтээж хэрэглэсэн байна

Неолитийн үед анхны зээтүүт газар тариалангийн эх үүсвэр тавигдсан юм. Гэвч эх газрын эрс тэс уур амьсгалтай Монгол оронд газар тариалан далайцтай хөгжиж чадаагүй юм. Неолитийн үеийн хүний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний бас нэг чухал шинэ ололт нь шавар ваар, сав бүтээн хийж хэрэглэх болсон явдал юм.

Неолитийн үед гарсан өөр нэг чухал дэвшил бол хүмүүс амьтны үс ноос, ургамал зэргийг ээрч утас хийгээд түүгээрээ бүдүүн ширхэгтэй даавуу хийж улмаар хувцас хийх болсон явдал билээ.

Монгол орны нутагт хийсэн чулуун зэвсгийн хайгуул судалгааны ажлын хүрээнд манай орны бараг бүх аймгийн нутгаас 800 гаруй чулуун зэвсгийн үеийн бууц, суурин, дархны газрыг олж илрүүлээд байна. Дэлхийн хүн төрлөхтөний соёлын гайхамшигтай дурсгалууд бүсүүдэд бий. Үүнийг ашиглах нь чухал

Хэдийгээр 800 гаран дурсгал илэрсэн ч түүх соёлын танин мэдэхүйн ач холбогдлоороо доорх 18 дурсгал тэргүүлдэг байна.

**Чулуун зэвсгийн бууц, суурин, дархны газрын тархац**

| № | Аймаг, хотын нэр | Сум, хотын нэр | Үл хөдлөх түүх, дурсгалын нэр |
|---|---|---|---|
| **Баруун бүс** | | | |
| 1 | Баян-Өлгий | Сагсай сум | Сагсайн голын чулуун зэвсгийн дурсгал |
| 2 | Баянхонгор | Өлзийт сум | Уран хайрханы чулуун зэвсгийн бууц |
| 3 | | Баянлиг сум | Зуухын шинэ чулуун зэвсгийн суурин |
| 4 | | | Цагаан агуйн чулуун зэвсгийн дурсгал |
| 5 | | Баян-Өндөр сум | Чихэн агуйн чулуун зэвсгийн дурсгал |
| **Төвийн бүс** | | | |
| 6 | Дорноговь | Эрдэнэ сум | Дулааны говийн шинэ чулуун зэвсгийн дурсгал |
| 7 | Дундговь | Гурвансайхан сум | Ярх уулын хуучин чулуун зэвсгийн бууц |
| 8 | Өвөрхангай | Богд сум | Арц богдын чулуун зэвсгийн суурин |
| 9 | | Хархорин сум | Мойлтын амны хуучин чулуун зэвсгийн үеийн бууц |
| 10 | | | Орхон-7 палеолитын буудал-дархны газар |
| 11 | Өмнөговь | Ноён сум | Оцон мааньтын чулуун зэвсгийн суурин |
| 12 | | Булган сум | Баянзагийн суурин |
| 13 | | | Цахиуртын хөндийн чулуун зэвсгийн дурсгал |
| **Зүүн бүс** | | | |
| 14 | Сүхбаатар | Мөнххаан сум | Устай Бургастайн шинэ чулуун зэвсгийн суурин |
| 15 | Хэнтий | Батширээт сум | Рашаан хадны палеолит, мезеолит, неолитийн үеийн суурин |
| | | | |
| 16 | Дорнод | Чойбалсан хот | Баруун Өлзийтийн неолитийн бууц, суурин |

| | | | |
|---|---|---|---|
| 17 | | | Овоотын суурин ба сууц |
| 18 | | Хуучин Тамсагбулаг сум | Тамсагбулагийн шинэ чулуун зэвсгийн бууц |

Дээрх тархацын хүснэгтэн доторх тодруулсан дурсгалуудыг ашиглан аялалын маршрут хөтөлбөр зохиох. Учир нь тодруулсан дурсгалууд нь хэмжээ, түүхэн он тоолол, агуулж байсан эд өлгийн зүйлсээрээ бусдаасаа хавьгүй илүү бөгөөд дээрх дурсгалт газруудаар аялснаар чулуун зэвсгийн үеийн хүмүүсийн аж амьдрал, соёл, түүхийн талаар танин мэдэх өндөр ач холбогдолтой юм.

*Тухайн аялалын хэрэглэгч нь*

Чулуун зэвсэгийн бууц суурингийг судлах үзэж сонирхох жуулчид нь хүн судлаач, археологичид, эрдэм шинжилгээ судалгааны ажилтнууд сонирхогчид байна. Бид бүс нутгийн хүрээнд очоод жуулчид үзэх боломжыг нь бүрдүүлсэн бичил музей байгуулах, тогтсон аялалын маршрутыг дангаар нь төлөвлөн хэрэглэгчид түгээх нь чухал. Бид энэ зах зээлийг эзлэх нь чухал. Өрсөлдөгчгүй зах зээл.

## *Хадны зураг*[18]

Монгол орон бол түүхийн өөр өөр цагт үе дамжин нутаглаж ирсэн ард түмнүүдийн аж ахуй оюун санааны өвөрмөц дурсгал болох хадны зургаар нэн баялаг орны тоонд зүй ёсоор ордог. Энэ нь Монголын хадны зураг хүй нэгдлийн байгууллын гүнд үүсч хөгжсөн олон арван мянган жилийн уламжлалтай холбоотой. Нөгөөтэйгүүр хадны зураг үеэс үе дамжин уламжлагдаж ирсэн нь түүний удаан хугацаагаар хадгалагдаж чадах байгалийн нөхцөлтэй холбоотой.

Төв Азийн анчид, нүүдэлчин малчдын хувьд өөрсдийн хүсэл эрмэлзлэлээ илэрхийлэн мөнхжүүлж хожуу үедээ уламжлах нэн тохиромжтой урлагийн хэлбэр нь хаданд зураг цоолборлон сийлж үлдээх арга байжээ.

Монгол орны нутаг дэвсгэрээс олдоод буй хадны зургийн дурсгалыг дүрсэлсэн арга барилын хувьд дараах үндсэн төрөлд хуваах болно. Үүнд:

1. Улаан зосоор зурсан зураг
2. Хадыг хонхойлон цоолборлож сийлсэн зураг
3. Хурц үзүүртэй багажаар зурсан нарийн зураасан зураг
4. Хар бэхээр зурсан зураг гэсэн төрлүүдэд хамруулдаг.

Хадны сийлмэл зураг нь тархац болон тооны хувьд зосон зураг, хурц үзүүртэй багажаар зурсан нарийн зураасан зураг, бэхээр зурсан зургаас олон зуу дахин их юм. Энэ нь хадны сийлмэл зураг бусад төрлийн зургаас бат бэх, илүү сайн хадгалагдах чанартай холбоотой бөгөөд түүнийг хаднаа цохиж сийлэх нь илүү боломжтой байсан байж болох юм.

Хадны сийлмэл зургийг дүрсэлсэн арга барилаар нь:

1. Бодит байдлаар дүрсэлсэн
2. Загварчлан дүрсэлсэн хэмээн хоёр төрөлд хуваан үздэг.

Одоогоор манай орны 200 орчим газраас хадны зураг олдож мэдэгдээд байгаа ба жил бүрийн судалгааны явцад нэмэн олдсоор байна. Эртний хүмүүсийн хад чулуунаа урлан үлдээсэн хадны зураг ихэвчлэн манай орны төв болон баруун хэсэгт өргөн тархсан бөгөөд зүүн хэсэгт цөөн тоогоор олддог.

Хадны зураг бол манай ард түмний эртний түүхийн нэгэн чухал сурвалж, тэр үеийн хүмүүсийн аж ахуй, нийгэм, оюун санааны хөгжлийн олон талыг тусгасан археологийн дурсгал билээ.

Монгол орны нутаг дэвсгэрт эрт цагаас, тухайлбал, хуучин чулуун зэвсгийн буюу палеолитийн үеэс ойролцоогоор 800 000 жилийн тэртээгээс хүн нутаглаж, үйлдвэрлэлээ явуулж аж төрөхдөө өөрийн соёлоо цогцлон бүтээж иржээ. Монгол оронд, тухайлбал, хадны зураг дээд палеолитийн үед Европ, Африк тивийнхтэй нэг ижил үед үүсчээ.

[18] [18] В.Мөнхбаяр. Докторын зэрэг горилох судалгааны ажил. 2012 он

Палеолитийн үеийн хадны зурагт дүрсэлсэн амьтдын зарим нь монгол нутагт амьдарч байгаад эрт үед мөхөж сөнөсөн (бар, тэмээн хяруул, арслан заан, савагт хирс болон зарим төрлийн буга), харин адуу, үхэр, тэмээг хожим гэршүүлж мал болгосон, аргаль, янгир, буга, гөрөөс зэрэг нь одоо зэрлэг хэвээрээ Монгол нутагт идээшлэн амьдарсаар байгаа билээ.

Хүрэл зэвсгийн үед (МЭӨ 3000-1000 жил) дөрвөлжин хашлага буюу дугуй хүрээн дотор олон тооны дугуй толбо, гадна нь хөтлөлцөж зогссон хэдэн хүн, хоёр зэрэгцээ замаар морь хөтөлж яваа хүнийг дүрсэлсэн хадны зосон зураг монгол нутагт өргөн тархсан байдаг.

Монгол орон хадны сийлмэл зургийн дурсгалаар нэн баялаг бөгөөд тэдгээрийн ихэнх нь хүрэл ба төмөр зэвсгийн үед холбогдоно. Энэ үеийн зурагт янгир, буга, чоно, үнэг зэрэг зэрлэг амьтад, үхэр, адуу, тэмээ зэрэг мал болон ан гөрөө хийж яваа хүмүүс, морь, тэмээ унасан хүн, ачаа нуруун дээр нь ачсан үхэр, морин тэрэг, иж бүрэн зэвсэглэсэн дайчин эрс, байлдаж байгаа хүмүүс зэргийг дүрсэлсэн байдаг.

Монголын эртний хадны зургийг бодит, тоймлосон, загварчилсан үндсэн гурван аргаар дүрсэлжээ.

Дээд палеолитийн үед амьтны хэвлий доор үржлийг бэлэгдсэн утгатай хонхор дүрслэх, нэг дүрийг дахин давтан зурахын оронд олон ижил толбоор төлөөлүүлэн дүрслэх зэрэг бэлэгдэлийг зохиомол тэмдгээр утгыг илэрхийлсэн зургууд зурдаг байсан нь мезолит, неолит, хүрэл, төмөр зэвсгийн үед ихээхэн дэлгэрч нэг газрын хаднаа хэдэн зуу хүртлэх тамга тэмдгийг дүрсэлдэг болсон байна. Манай хөрш зэргэлдээ оронд хад чулуунаа тамга тэмдгийг хэдийгээр дүрсэлж байсан боловч Монгол оронд энэ заншил бусдаас илүү давамгай хөгжиж байсан онцлогтой.

Монгол болон Төв Азийн хүрэл ба төмөр зэвсгийн эртний урлалд “амьтны загварт арга” онцгой байрыг эзэлнэ. Энэ аргаар урласан хадны зураг Монгол нутагт хүрэл зэвсгийн үед (МЭӨ XII-YIII зууны үед үүсч МЭӨ YII-III зуун хүртэл) өргөн тархжээ.
Манай орны бараг бүх аймгийн нутгаас илэрч олдсон хадны зурагт янгирын дүрс сийлж урлаагүй хадны зураг бараг үгүй. Янгирыг хад чулуунаа дүрслэх явдал Төв Азийн уужим нутагт нэн эртнээс өргөн дэлгэрсэн болох нь судлагдан нийтлэгдсэн хадны зургийн олон зуун дурсгалаас тодорхой харагддаг.
Төв Азийн анчид, нүүдэлчин малчдын хувьд өөрсдийн хүсэл эрмэлзлэлээ илэрхийлэн мөнхжүүлж хожуу үедээ уламжлах нэн тохиромжтой урлагийн хэлбэр нь хаданд зураг цоолборлон сийлж үлдээх арга байжээ.

**Хадны зургийн тархац аялал жуулчлалын бүс нутгаар**

| № | Аймаг, хотын нэр | Сум, хотын нэр | Үл хөдлөх түүх, дурсгалын нэр |
|---|---|---|---|
| **Төвийн бүс** | | | |
| 1 | Архангай | Жаргалант сум | Улиастайн голын хадны зураг |
| 2 | | Тариат, Өндөр-Улаан | Суман голын хадны зураг |
| 3 | | Батцэнгэл | Хөрөөгийн үзүүрийн хадны зураг |
| 4 | Өмнөговь | Ноён сум | Аравжихын хадны зураг |
| 5 | | | Завсар уулын хадны зураг |
| 6 | | Номгон сум | Долоон уулын хадны зураг |
| 7 | | | Уртын голын хадны зураг |
| 8 | | Сэврэй сум | Сэврэйн хадны зураг |
| 9 | Булган | Дашинчилэн сум | Арслантын хадны зураг |
| 10 | | Орхон сум | Баруун могойн хадны зураг |
| 11 | | Бүрэгхангай сум | Шовгор зороогийн хадны зураг |
| 12 | Дундговь | Дэлгэрцогт сум | Гэр чулуу, Бага газрын чулууны хадны зураг |
| 13 | | Өлзийт сум | Билүүгийн хадны зураг |
| 14 | | | Өлзийтийн хадны зураг |
| 15 | | Дэлгэрхангай сум | Хар хашаатын амны хадны зураг |
| 16 | | Баянжаргалан сум | Цагаан айргийн хадны зураг |

| | | | |
|---|---|---|---|
| 17 | Өвөрхангай | Зүүнбаян-Улаан сум | Ар цохиотын хадны зураг |
| 18 | | Арвайхээр сум | Буга Соготын хадны зураг |
| 19 | | Бат-Өлзийт сум | Орхоны дээд биеийн хадны зураг |
| 20 | | Богд сум | Тэвш уулын хадны зураг |
| 21 | Төв | Өндөрширээт сум | Дөрвөлжингийн хадны зураг |
| 22 | | | Их Алагийн хадны зураг |
| 23 | | Алтанбулаг сум | Морин толгойн хадны зураг |
| 24 | Дархан-Уул | | Шарын голын зосон зураг |
| | | | |
| **Баруун бүс** | | | |
| 25 | Баянхонгор | Баянлиг сум | Бичигтын амны хадны зураг |
| 26 | | Жаргалант сум | Бугатын хадны зураг |
| 27 | | Бууцагаан сум | Гурван Мандалын хадны зураг |
| 28 | | Баян-Өндөр сум | Саальтын агуйн хадны зураг |
| 29 | | Ханбогд сум | Жавхлант хайрханы хадны зураг |
| 30 | Говь-Алтай | Баян-Уул сум | Доогийн ханангийн бууцны хадны зураг |
| 31 | | Бигэр сум | Бичигт хадны хадны зураг |
| 32 | | | Морин толгойн буюу Молор толгойн хадны зураг |
| 33 | | Халиун сум | Цагаан голын хадны зураг |
| 34 | | Чандмань сум | Шаахар толгойн хадны зураг |
| 35 | Завхан | Баянхайрхан сум | Талын ухаагийн ацын хадны зураг |
| 36 | Увс | Сагил сум | Ганц харгайтын бичигт хадны зураг |
| 37 | | | Шовгор хадны зураг |
| 38 | | | Зүүн турагийн тэрэм хадны зураг |
| 39 | | | Их сарын хадны зураг |
| 40 | | | Можоогийн хадны зураг |
| 41 | | | Бургастайн хөндийн Ганцхаргайтын бичигт хадны зураг |
| 42 | | | Цагаан өтөгийн хадны зураг |
| 43 | | | Үнхэлцэгийн хадны зураг |
| 44 | | | Хад үзүүрийн хадны зураг |
| 45 | | Давст сум | Мөнгөт Цахирын хадны зураг |
| 46 | | | Тэхтийн давааны хадны зураг |
| 47 | | Зүүнхангай сум | Зураагийн улаан хадны зураг |
| 48 | | Наранбулаг сум | Наранбулагийн хадны зураг |
| 49 | | Баруутуруун сум | Хар Цагаан усны хадны зураг |
| 50 | | Өлгий сум | Шар булгийн онцын хадны зураг |
| 51 | Баян-Өлгий | Толбо сум | Баян-Энгэрийн хадны зураг |
| 52 | | Цэнгэл сум | Арал толгойн хадны зураг |
| 53 | | Баяннуур сум | Урт харын хадны зураг |
| 54 | | Бугат сум | Халзан булагийн хадны зураг |
| 55 | | Улаанхус сум | Хар ямаагийн хадны зураг |
| 56 | | | Цагаан салаагийн хадны зураг |
| 57 | Ховд | Манхан сум | Ишгэн толгойн хадны зураг |
| 58 | | | Хойд цэнхэрийн агуйн хадны зураг |
| 59 | | Жаргалан сум | Ховд хот орчмын хадны зураг |
| 60 | | Эрдэнэбүрэн сум | Хонгиогийн голын хадны зураг |
| 61 | | | Цамбагаравын хадны зураг |
| 62 | | | Хөшөөтийн хадны зураг |
| 63 | | Буянт сум | Чандмань хар үзүүрийн хадны зураг |
| 64 | | Үенч сум | Ямаан усны хадны зураг |
| **Зүүн бүс** | | | |

| | | | |
|---|---|---|---|
| 65 | Хэнтий | Батширээт сум | Үзүүр цохионы хадны зураг |
| 66 | | | Рашаан хадны зураг, дурсгал |
| 67 | Сүхбаатар | Онгон сум | Бударын чулууны хадны зураг |
| **Улаанбаатарын бүс** | | | |
| 68 | Улаанбаатар хот | | Гачуургын амны хадны зураг |
| 69 | | | Их Тэнгэрийн амны хадны зураг |
| | | | |

Дээрх тархацын хүснэгтэн доторх тодруулсан дурсгалуудыг ашиглан баруун аймгуудын нутгаар аялах аялалын маршрут хөтөлбөр зохиосон. Учир нь тодруулсан дурсгалууд нь дүрслэлийн арга барилаар баялаг, дүрсэлсэн сэдэв нь өргөн хүрээг хамарсан, түүхэн цаг үеэ сайн илэрхийлж чадсан зэрэг өндөр ач холбогдолтой юм. Зарим зурагт одоо Монгол нутаг байдаггүй амьтдыг дүрсэлсэн байдаг нь тухайн цаг үедээ монгол нутагт маань хирс, арслан заан зэрэг эрт цагт мөхсөн амьтад амьдарч байсныг баталж өгдөг.

*Тухайн аялалын хэрэглэгч нь*

Хадны сүг зураг судлах, үзэж сонирхох жуулчид нь хүн судлаач, археологичид, эрдэм шинжилгээ судалгааны ажилтнууд, зураач, баримлач, түүхч, сонирхогчид байна. Гол стратеги нь дагнасан маршрутыг төлөвлөх, орчны бүсэд нутгийн иргэдэд түшиглэсэн баазыг стандартын дагуу барьж байгуулах. Өрсөлдөгчгүй зах зээл.

## *Буган хөшөө*[19]

Буган хөшөө бол Монгол болон Төв Азийн нутаг дэвсгэр дээр хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үед оршин сууж байсан овог аймгийн түүх соёлын гайхамшигтай дурсгалын нэг билээ.

Гонзгой урт чулууг засч, гурав зааглан, оройн хэсэгт нар сар, доогуур нь олон эгнээ хонхор, эх биеийг ороолгон төв хэсэгт сүрэг бугыг загварчилсан байдалтайгаар ихэд сүрлэг сийлж, бас доогуур нь бүс татан зэр зэвсгийг зүүсэн байдалтай дүрсэлсэн хөшөө чулууг буган хөшөө хэмээн нэрлэдэг.

Хөшөөнөө дайчин эрийн зэвсэг болох чинжал хутга, билүү, байлдааны алх, сүх, нум, саадаг, хоромсого, жад, бамбай, зээтүү, толь дүрслэхээс гадна хөшөөний бүсийг олон төрлийн хээгээр чимсэн байдаг ба мөн бугын дүрсний оронд буюу завсар зайд адуу, ирвэс, янгир, зээр зэрэг амьтад хаая дүрсэлсэн байдаг. Тийм дүрстэй хөшөө тооны хувьд тун цөөн, өргөн тархаагүй, мөн сонгодог хэлбэрийн буган хөшөөний зохиомж хөшөөнөө сийлсэн тамга, бүс, зэр зэвсгийн хувьд төдийлөн онц ялгагдах зүйлгүй байдаг.

Ази, Европ тивийн хээр талын бүс нутагт хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үед өргөн тархсан түүх соёлын гайхамшигт дурсгал болох буган хөшөөг эрдэмтэд 100 орчим жилийн тэртээгээс судлаж 700 орчим буган чулуун хөшөөг олж илрүүлжээ. Эдгээрээс хамгийн их буюу 550 орчим нь Монгол улсын нутгаас олджээ.

Буган хөшөөг хэлбэр төрхийн хувьд үндсэн гурван төрөлд хуваан авч үздэг. Үүнд:

1. Монгол-Өвөрбайгалын бугын загварчилсан дүрс бүхий буган хөшөө
2. Саян-Алтайн амьтны "бодит" дүрст буган хөшөө
3. Ази-Европын амьтны дүрсгүй буган хөшөө хэмээн ангилдаг байна.

Эхний төрөлд хамаарах буган хөшөө тооны хувьд хамгийн олон байдаг бөгөөд манай орны Архангай, Өвөрхангай, Завхан, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Төв, Сэлэнгэ, Хөвсгөл, Хэнтий, Ховд, Увс, Баян-Өлгий аймгийн нутагт олдоод байгаа боловч гол шигүү тархсан төв нь Хангай, Хэнтийн уулс орчмын нутаг юм.

Буган хөшөө бол Төв Азийн эртний нүүдэлчин ард түмний бүтээсэн амьтны загварт урлагийн нэгэн гайхамшигтай төрөл бөгөөд түүхэн он цагийн хувьд ихэвчлэн МЭӨ II-I мянган жилд буюу хүрэл зэвсгийн үед хамаардаг юм. Босоо чулуун хөшөөнд бугын дүрс сийлсэн байдаг учраас түүнийг "Бугын хөшөө" гэж нэрлэжээ.

19 [19] В.Мөнхбаяр. Докторын зэрэг горилох судалгааны ажил. 2012 он

Дэлхий дээр зөвхөн Ази тивд 700 гаруй байдаг. Энэ төрлийн хөшөөний 500-гаад нь монгол нутагт байдаг бол түүний 100 гаруй нь Архангай аймгийн нутагт байна.

Архангай аймгийн нутгаас олдсон буган хөшөөнүүдийг урласан арга барил, зан үйл, түүх соёлын утга агуулгыг нягтлан өөр хооронд нь харьцуулан үзэхэд буган хөшөөний гол цөм болох ерөнхий төрх шинжээс гадна янз бүрийн утга санаа, билэгдэл, дүр дүрслэлийн онцлогууд, олон янз байдал нэлээд ажиглагдаж байдаг.

**Буган хөшөөний тархац аялал жуулчлалын бүс нутгаар/голлох/**

| № | Аймаг, хотын нэр | Сум, хотын нэр | Үл хөдлөх түүх, дурсгалын нэр |
|---|---|---|---|
| | | **Төвийн бүс** | |
| 1 | Архангай | Тариат, Өндөр-Улаан сум | Шивэртийн амны буган хөшөө |
| 2 | | Ихтамир сум | Алтан сандал уулын буган хөшөө |
| 3 | | | Хавцлын амны буган хөшөө |
| 4 | | | Баянцагааны адагийн буган хөшөө |
| 5 | | | Баянцагааны хөндийн буган хөшөө |
| 6 | | | Цацын эрэгийн буган хөшөө |
| 7 | | Эрдэнэмандал сум | Бөмбөгөр уулын буган хөшөө |
| 8 | | | Их жаргалантын дурсгал |
| 9 | | | Хүнүй голын буган хөшөө |
| 10 | | Хайрхан, Эрдэнэмандал сум | Уртын амны буган хөшөө |
| 11 | | Өндөр-Улаан сүм | Жаргалантын буган хөшөө |
| 12 | | | Чулуут, Тээлийн голын бэлчирийн буган хөшөө |
| 13 | | Цэнхэр сум | Хөшөөтийн амны буган хөшөө |
| 14 | | Хотонт сумын төв | Буган хөшөө |
| 15 | | Цэцэрлэг хот | Арцатын амны буган хөшөө |
| 16 | | | Буган хөшөө |
| 17 | | Өлзийт сум | Мөнгөний хөндийн буган хөшөө |
| 18 | | Батцэнгэл сум | Шивэртийн амны буган хөшөө |
| 19 | Булган | Сайхан сум | Асган дэвсгийн буган хөшөө |
| 20 | | Орхон сум | Буган хөшөө |
| 21 | | Тэшиг сум | Буган хөшөө |
| 22 | | Хишиг-Өндөр сумын төв | Буган хөшөө |
| 23 | | Ногоон нуур сум | Хар магнайн хөшөө |
| 24 | Өвөрхангай | Бат-Өлзийт сум | Тэмээн чулууны буган хөшөө |
| 25 | | Баян-Өндөр сум | Бууралын хөшөө |
| 26 | Сэлэнгэ | Орхонтуул сум | Өгөөмөр уулын буган хөшөө |
| 27 | Төв | Алтанбулаг сум | Морин толгойн буган хөшөө |
| 28 | | Бугат сум | Дунд нуурын буган хөшөө |
| 29 | Хөвсгөл | Чандмань-Өндөр сум | Бадарын нурууны буган хөшөө |
| 30 | | | Булжихын голын буган хөшөө |
| 31 | | Цагаан-Уул сум | Бор Хужирийн голын буган хөшөө |
| 32 | | Арбулаг сум | Бадрахын өврийн буган хөшөө |
| 33 | | Галт сум | Галтын буган хөшөө |
| 34 | | Галт сум | Нүхтийн амны буган хөшөө |
| 35 | | Төмөрбулаг сум | Зуны голын буган хөшөө |

| | | | |
|---|---|---|---|
| 36 | | Мөрөн сум | Уушгийн өврийн буган хөшөө бүхий дурсгал |
| 37 | | Бүрэнтогтох сум | Хядагийн эхний буган хөшөө |
| 38 | | Шинэ-Идэр сум | Цохиотын амны буган хөшөө |
| 39 | | | |
| **Зүүн бүс** | | | |
| 40 | Хэнтий | Батширээт сум | Бииндэрийн буган хөшөө |
| 41 | | Өмнөдэлгэр сум | Жаргалантын буган хөшөө |

Тархацын хүснэгтэн дэх тодруулсан буган хөшөөн дурсгалт газраар аялах аялалын маршрут зохиосноор буган хөшөөний онцлог, түүнийг хэрхэн, хэнд зориулж бүтээсэн талаар мэдлэгтэй болох юм. Эдгээр буган хөшөөд нь ур хийц, хэлбэр маяг зэргээрээ нэлээд онцлог оюун санааны бүтээл болж чадсан байдаг.

***Тухайн аялалын хэрэглэгч нь***

Буган хөшөөг судлах, үзэж сонирхох жуулчид нь хүн судлаач, археологичид, эрдэм шинжилгээ судалгааны ажилтнууд, зураач, баримлалч, түүхч, сонирхогчид байна. Гол стратеги нь дагнасан маршрутыг төлөвлөх, орчны бүсэд нутгийн иргэдэд түшиглсэн баазыг стандартын дагуу барьж байгуулах. Дэлхийд 750 орчим байгаагаас манай оронд 550 орчим бий.

**Хүн чулуу[20]**

Хүн чулуу хэмээх нь Евразийн тал нутгаар их хэмжээгээр тархсан, нүүдэлчин овог аймгуудын бүтээсэн чулуун цоолбор урлагийн өвөрмөц дурсгал юм. Хүн чулууг төр улс, овог аймгийн тэргүүн буюу цэрэг дайны алдар гавьяатан зэрэг нэр цуут хүний дурсгалд зориулсан тахилын онгоны бүрэлдэхүүнд оруулан тавьсан байдаг.

Эдгээрийг урлан бүтээхдээ байгалын бэлэн чулууг засч янзлан хүний биеийн хэлбэр оруулж хийсэн байх ба ур хийцийн хувьд харилцан адилгүй байдаг. Хүн чулуу нь түүхэн тодорхой цаг үед амьдарч байсан биет хүнийг дууриалган хийсэн хөшөө дурсгал болохын хувьд тэр үеийн хүний хувцас өмсгөл, гэзэг үс, зэр зэвсэг, гоёл чимэглэл, зарим эд зүйлсийг бодитойгоор дүрслэн гаргасан байна. Хүн чулуу нь Монгол улсын бүх аймгийн нутаг дэвсгэрт олон цөөн, янз бүрийн хэмжээгээр илрэн олдож бүртгэгдсэн бөгөөд тэдгээр нь түүх-соёлын хамаарал болон он цагийн хувьд 2 үндсэн бүлэгт багтаж байна. Үүнд, манай орны төв болон баруун талын нутгаар их хэмжээтэй байх хүн чулууд нь VI-IX үед холбогдох түрэг угсаат аймгуудын бүтээсэн хүн чулуу, зүүн талын нутгаар зонхилон оршдог XIII-XIV зууны монголын соёлд холбогдох хүн чулуу зэрэг болно. Одоогоор Монгол улсын нутагт 500 гаруй хүн чулуу илрэн мэдэгдэж бүртгэгдээд байна. Хүн чулууг Монгол нутагт өргөн тархацтай боржин чулуугаар голчлон хийх ба үүний зэрэгцээ элсэн чулуу, занар, хүрмэн чулуу зэрэг тухайн орон нутагт олдоц элбэгтэй чулуугаар ч хийсэн байдаг.

Манай улсын бүх аймгийн нутгаас хүн чулууны дурсгал олдсон бөгөөд одоогийн байдлаар 500 гаруй хүн чулуу бүртгэгдээд байгаа юм байна. Эдгээр дурсгалуудыг түүх, соёлын хамаарал болон он цагийн хувьд нь хоёр үндсэн бүлэгт хуваадаг. Эхнийх нь монгол орны төв болон баруун талын нутгаар байх VI-IX зууны үед холбогдох Түрэгийн үеийн хүн чулуу, нөгөө хэсэг нь зүүн талын нутгаар зонхилон байх XIII-XIV зууны Их монгол улсын үеийн хүн чулуу юм. Түрэгийн үеийн хүн чулуу нь тооны хувьд дийлэнх хэсгийг эзэлдэг.

Их монгол улсын үед хамаарах хүн чулуудын ерөнхий төрх нь баруун гартаа хундага сав барьж түшлэгтэй сандалд суусан эр хүний дүрс зонхилдог, түрэгийн хүн чулуунд байдаг шиг зэл чулуу байдаггүй. Тухайн үеийн монгол эрчүүдийн гэзэг үсний хэлбэр нь хоёр чихний араар багцлан боож унжуулсан багц үс, мөн дух руу унжуулсан гөхөл бөгөөд тэр үед монголд ирж байсан гадны элч төлөөлөгчдийн тэмдэглэн бичсэн тэмдэглэлтэй яг тохирдог байна. Мөн урт нарийн ханцуйтай, зөв тийш дарсан ташуу энгэртэй халхгар дээлтэй байдаг

20 [20] В.Мөнхбаяр. Докторын зэрэг горилох судалгааны ажил. 2012 он

нь тэр үеийн уран зургийн дурсгалтай ч яг тохирдог байна. Гутлын хэлбэр дүрс нь ч дундад зууны монголчуудын гутал ямар байсныг тодорхой харуулдаг байна. Их монголын үед холбогдох эдгээр хүн чулуунуудыг хамгийн ихээр агуулдаг газар бол Сүхбаатар аймгийн нутаг бөгөөд "Дарьгангын хүн чулуу" хэмээн алдаршчээ.

**Хүн чулууны тархац аялал жуулчлалын бүс нутгаар**

| № | Аймаг, хотын нэр | Сум, хотын нэр | Үл хөдлөх түүх, дурсгалын нэр |
|---|---|---|---|
| **Төвийн бүс** | | | |
| 1 | Архангай | Ихтамир сум | Баянцагааны хүн чулуу |
| 2 | | Тариат сум | Дадгын өвөлжөөний хүн чулуу |
| 3 | | Хотонт сумын төв | Хүн чулуу |
| 4 | | Хайрхан сум | Эмээл толгойн хүн чулуу |
| 5 | Булган | Хутаг-Өндөр сум | Гуртын гүүр орчмын хүн чулуу |
| 6 | | Булган хот<br>Сэлэнгэ сум<br>Сайхан сум | Зүүн түрүүний хүн чулуу |
| 7 | | | Ингэт толгойн хүн чулуу |
| 8 | | | Нарийн хүрэмтийн хүн чулуу |
| 9 | | Алтай сум | Хаан ширээ хад |
| 10 | | Дэлүүн сумын төв | Хүн чулуу |
| 11 | | Ногоон нуур сумын төв | Хүн чулууд |
| 12 | | Баяннуур сум | Олон нуурын Алаг толгойн хүн чулуу |
| 13 | | | Цагаан хөшөөтийн хүн чулуу |
| 14 | | | Хайртын голын хүн чулуу |
| 15 | | Улаанхус сум | Хар ямаатын голын хүн чулуу |
| 16 | | | Хатуугийн амны хүн чулуу |
| 17 | | | Ганц модны булгийн бүлэг дурсгал |
| 18 | Говьсүмбэр | Сүмбэр сум | Зараагийн зүүн өврийн хүн чулуу |
| 19 | Дорноговь<br>Дорнод | Иххэт сум | Ар улааны хүн чулуу |
| 20 | | Матад сум | Ловхын хүн чулуу |
| 21 | Дундговь | Сүмбэр сум | Шонх таван толгойн хүн чулуу |
| 22 | | Дундговь аймгийн музей | Сариг Хайрханы хүн чулуу |
| 23 | Өвөрхангай | Баруунбаян-Улаан сум | Тарималын өвөлжөөний хүн чулуу |
| 24 | | | Дэмчигбурамын хүн чулуу |
| 25 | | Уянга сум | Онгийн голын дурсгал |
| 26 | | | Хадан хошууны хүн чулуу |
| 27 | | Аймгийн музей | Хүн чулууд |
| 28 | | Бүрд сум | Тарны голын хүн чулуу |
| 29 | | Хархорин сум | Бага Эрээний хүн чулуу |
| 30 | | | Хөшөөн дэнж буюу Бумбатын өврийн хүн чулуу |
| 31 | Өмнөговь | Номгон сум | Уртын амралтын хүн чулуу |
| 32 | Төв | Баян сум | Өгөөмөрийн хүн чулуу |
| **Зүүн бүс** | | | |
| 33 | Сүхбаатар | Дарьганга сум | Алтан овооны хүн чулуу |
| 34 | | | Гөхөлийн ширээний хүн чулуу |
| 35 | | | Ламтын хүн чулуу |
| 36 | | | Хөргийн хөндийн хүн чулуу |
| 37 | | Онгон сум | Таван толгойн хүн чулуу |
| 38 | | | Шивээтийн хүн чулуу |

| | | | |
|---|---|---|---|
| 39 | Хэнтий | Дэлгэрхаан сум | Гүн бүрдийн хүн чулуу |
| 40 | | Батширээт сум | Живхээстэйн амны хүн чулуу |
| 41 | | Өндөрхаан сум | Хүн чулуу |
| **Баруун бүс** | | | |
| 42 | Говь-Алтай | Тонхил сум | Зүйлийн Огторгын хүн чулуу |
| 43 | | Жаргалант сум | Сүмийн дэнгийн хүн чулуу |
| 44 | | Наранбулаг сум | Тоосготын хүн чулуу |
| 45 | | Бугат сум<br>Эрдэнэ сум | Тамчийн бэлчирийн хүн чулуу |
| 46 | | | Дэвэрхийн эхийн хөшөө чулуу |
| 47 | | Тариалан сум | Халхайтын дэнжийн хүн чулуу |
| 48 | | Малчин сум | Хөтөл нуурын Улаан толгойн хүн чулуу |
| 49 | Ховд | Мөнххайрхан сум | Улаан говийн амны хүн чулуу |
| 50 | | | Шуурхайн хөх нуурын хүн чулуу |

Сүхбаатар аймаг дахь хүн чулууд нь Их монгол улсын үед хамаарах бөгөөд хэлбэр хийц, урласан арга барилаараа нэн өвөрмөц дурсгалууд юм

*Тухайн аялалын хэрэглэгч нь*

Хүн чулуу судлах, үзэж сонирхох жуулчид нь хүн судлаач, археологичид, эрдэм шинжилгээ судалгааны ажилтнууд, зураач, барималч, түүхч, сонирхогчид байна. Гол стратеги нь дагнасан маршрутыг төлөвлөх, орчны бүсэд нутгийн иргэдэд түшиглсэн баазыг стандартын дагуу барьж байгуулах.

**Булш, хиргисүүр**[21]

Монгол улсын нутаг дэвсгэр дээр шинэ чулуун зэвсгийн үеийн оршин суугчдаас эхлэн өнөөдрийг хүртэл амьдарч ирсэн овог аймаг, төр улсууд өөр өөрийн өвөрмөц онцлог шинжтэй оршуулгын зан үйл бүхий төрөл бүрийн хэлбэр дүрстэй оршуулгын байгууламжийг үлдээсэн нь археологийн хайгуул судалгаагаар тодорхой болжээ. Оршуулгын зан үйл нь тухайн угсаатны ёс заншил, сүсэг бишрэл болон эрхлэх аж ахуй, газар нутгийн онцлог мэдлэг оюуны төвшнөөс хамааран харилцан адилгүй нөхцөлд бүрэлдэн бий болдог байна.

Манай улсын нутгаас илэрч олддог булш оршуулгыг чулуун зэвсгийн үеийн булш оршуулга, дөрвөлжин булш, хиргисүүр, хүннү булш, түрэг булш, монгол үеийн булш хэмээн хуваан авч үздэг. Хэдэн арваас хэдэн зуу хүртлэх тооны булш бунхан бүхий овгийн оршуулгын газар нэг дор байхаас гадна ганц хоёр буюу цөөн хэдэн булш бүхий оршуулгын газар элбэг тохиолдоно. Энэ нь юуны өмнө нүүдэлчид нэг дор урт удаан хугацаагаар суурьшин амьдардаггүй, жилийн дөрвөн улиралд нүүж байдгаар тайлбарлагдана.

Дөрвөлжин булш нь Монголын хүрэл зэвсгийн үеийн археологийн томоохон дурсгалын нэг юм. Дөрвөлжин булш жижиг толгодын орой шил, даваа хөтөл дээр ганц нэг, хоёр гурвaараа тохиолдохоос гадна тэднийг гол төлөв уулын энгэр, бэл, аманд мөн тэгш талын дунд нэг дор арваас хэдэн арав хүртэл тоотой хэсэг бүлгээр нь барьж байгуулсан байдаг.

Хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булшнаас илрэн олдож буй эд өлгийн зүйлсийг ерөнхийд нь зэр зэвсэг, байлдааны хэрэглэл, аж ахуй, хөдөлмөрийн багаж хэрэгсэл, гоёл чимэглэлийн зүйлс хэмээн төрөлжүүлэн хуваадаг. Манай улсын нутагт одоогийн байдлаар ойролцоогоор 500 гаруй дөрвөлжин булшийг малтан судлажээ.

Хиргисүүр нь хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үеийн өвөрмөц дурсгал юм. Манай орны нутаг дэвсгэрт хиргисүүр маш өргөн хэмжээгээр тархсан байдаг бөгөөд харин бусад булшуудыг бодвол харьцангуй бага малтан судлагдсан байна.

Хүннүгийн булш нь газрын хөрсөн дээр өвсөн бүрхэвчтэй хөрсөн дээр чулуу өрж тавьсан далангаар мэдэгддэг**.** Гаднах чулуун далан нь дугуй, дөрвөлжин хоёр янзын хэлбэртэй байх бөгөөд үүдэвч зэрэг нэмэлт байгууламж, хэмжээгээрээ харилцан адилгүй байдаг. Хүннүгийн үед холбогдох булш бунханыг оршуулгын зан үйл, гаднах хэлбэр төрх, дагалдуулсан эд

21 [21] В.Мөнхбаяр. Докторын зэрэг горилох судалгааны ажил. 2012 он

зүйлс зэргээр нь язгууртны болон жирийн иргэдийн гэж хуваадаг. Энэ хоёр булш нь гаднах төрх байдал, зохион байгуулалтаараа эрс ялгаатай байдаг төдийгүй булшнаас гарч байгаа эд өлгийн зүйлсээрээ ч ялгагдана

Одоогийн Монгол улсын нутаг дэвсгэр нь Хүннүгийн уугуул нутаг учраас гол булш оршуулга нь манай нутагт байдаг. Манай орны 15 аймгийн 50 орчим газраас 3000 орчим хүннү булш илэрч мэдэгдээд байна.

Эртний түрэгүүд нас барагсдаа булшлан оршуулахын зэрэгцээ тэдний сүнсийг амаржуулах зорилгоор олноор цуглан тахил тайлгын зан үйл гүйцэтгэх онгоны газрыг тусад нь байгуулдаг байжээ.

Монгол нутагт нэн эрт цагаас оршин амьдарч байсан хүмүүсийн оршуулгын зан үйл, нас барагчаа хүндэтгэн, “хойт нас”-нд нь үдэхтэй холбогдсон зан үйлийн янз бүрийн уламжлал, сэтгэлгээг илэрхийлсэн, хүрэл, төмөр зэвсгийн үед холбогдох, мөн төрт улсуудын үеийн буюу Хүнну, Түрэг, Уйгар, Кидан, Монголын үеийн гээд түүхийн олон үед хамаарах янз бүрийн дүр төрхтэй булш, хиригсүүрүүд Архангай, Өвөрхангай аймгуудын нутагт элбэг тохиолддог. Харин монгол булш хиргисүүрүүд Хэнтий аймгийн нутагт элбэг байдаг.

**Булш хиргисүүрийн тархац аялал жуулчлалын бүс нутгаар**

| № | Аймаг, хотын нэр | Сум, хотын нэр | Үл хөдлөх түүх, дурсгалын нэр |
|---|---|---|---|
| | | **Төвийн бүс** | |
| 1 | Архангай | Хайрхан сум | Хана уулын хиргисүүр |
| 2 | | | Гол модны Хүннүгийн булш |
| 3 | | | Дэлэн толгойн монгол булш |
| 4 | | | Наймаа толгойн хүнну булш |
| 5 | | Батцэнгэл сум | Солби уулын хүнну булш |
| 6 | | | Худгийн толгойн хүнну булш |
| 7 | | Тариат сум | Алтан сандал уулын булш |
| 8 | | Хашаат сум | Хөшөө цайдамын бунхант булш |
| 9 | | | Хөшөө цайдамын бунхант булш |
| 10 | Булган | Бүрэгхангай сум | Өвгөнтийн булш |
| 11 | | | Тооройн амны хүнну булш |
| 12 | | Хутаг-Өндөр сум | Тээлийн монгол булшнууд |
| 13 | | | Холтост нугын хүрэл дуулгат дөрвөлжин булш |
| 14 | | | Эмгэнт хошууны хүрэл дуулгат дөрвөлжин булш |
| 15 | Хөвсгөл | Галт сум | Нухтийн амны булш |
| 16 | | Их-Уул сум | Сул толгойн булш |
| 17 | Дархан-Уул | Дархан-Уул аймаг | Төмөртэйн хүнну булш |
| 18 | Дорнод | Гурванзагал сум | Гурванзагалын дөрвөлжин булшнууд |
| 19 | | Булган сум | Норовлингийн неолитийн булш |
| 20 | | Дорнод аймаг | Хоолтын голын бүлэг булш |
| 21 | | Чойбалсан хот | Бүлэг булш |
| 22 | | | Неолитийн үеийн булш |
| 23 | Дундговь | Дэлгэрцогт сум | Бага газрын чулууны хүннүгийн булш |
| 24 | Өвөрхангай | Хархорин сум | Бага арцатын монгол булш |
| 25 | | | Жаргалантын хиргисүүр |
| 26 | | | Маамуу толгойн булш |
| 27 | | | Хархорин хотын турийн орчим дахь лалын шашинтны оршуулга |

| | | | |
|---|---|---|---|
| 28 | | Өлзийт, Зүйл сумд | Тарвагатайн амны булш |
| 29 | | Богд сум | Тэвш уулын хүннү булш |
| 30 | | Уянга сум | Оньтольтын хүннү булш |
| 31 | | Хужирт сум | Хүүшийн хөтлийн хүннү булш |
| 32 | Сэлэнгэ | Хонгор сум | Буурал уулын монгол булшнууд |
| 33 | Төв | Алтанбулаг сум | Морин толгойн олон үеийн булш |
| 34 | | Батсүмбэрсум | Ноён уулын хүннүгийн булшнууд |
| 35 | | Баян-Өнжүүл сум | Хайрхан уулын хүннү булш |
| **Баруун бүс** | | | |
| 36 | Говь-Алтай | Цогт сум | Хиргист хоолойн булш |
| 37 | | Тонхил сум | Хяр хараачийн булш, хиргисүүрийн бүлэг дурсгал |
| 38 | Увс | Улаангом хот | Чандмань уулын булш |
| 39 | Ховд | Манхан сум | Тахилтын хотгорын хүннү булш |
| **Зүүн бүс** | | | |
| 41 | Хэнтий | Биндэр сум | Асгатын дөрвөлжин булш |
| 42 | | | Бор булгийн амны булш дурсгал |
| 43 | | Жаргалтхаан сум | Дуулга уулын хүннү булш |
| 44 | | Баян-Адарга сум | Дуурлиг нарсны хүннү булш |
| 45 | | Өмнөдэлгэр сум | Дэд өлзийтийн дөрвөлжин булш |
| 46 | | | Хурх-Жаргалантын булш |
| 47 | | | Төгс өндөрийн булш |
| 48 | | Цэнхэрмандал сум | Устын амны дөрвөлжин булш |
| 49 | | Дэлгэрхаан сум | Хүйтэн хошууны монгол булш |
| 50 | | Батширээт сум | Ёлын байцын дөрвөлжин булш |
| 51 | | | Эгийн живхээстэйн булш |
| 32 | Сүхбаатар | Түвшинширээ сум | Бага Өлзийтийн монгол булш |
| **Улаанбаатарын бүс** | | | |
| 52 | Улаанбаатар | | Сонгино Хайрханы салбар Дадарт уулын монгол булш |

Тархацын хүснэгтэн дэх тодруулсан дурсгалаар аялалах нь монгол нутаг дахь булш, хиргисүүрийн талаар ойлголттой болохоос гадна, эдгээр булш, бунхны онцлог, хэнд зориулж, ямар аргаар барьсан талаар мэдэх юм. Дээрх булш дурсгалууд нь одоогийн байдлаар монгол орноос олдсон булш, хиргисүүрийн дотроос хэмжээгээр том, түүхийн чухал судлагдахуун, дотроос нь олдсон олдвор зэргээсээ бусдаасаа ялгарч чадахуйц онцлогтой билээ.

*Тухайн аялалын хэрэглэгч нь*

Булш хиргэсүүрийг үзэж сонирхох жуулчид нь хүн судлаач, археологичид, эрдэм шинжилгээ судалгааны ажилтнууд, түүхч, булш судлаачид, сонирхогчид байна.

**Эртний хотын турь, хэрэм, балгас** [22]

Монгол угсаатнууд эрт дээр үеэс эсгий гэрт сууж нүүдэллэн амьдрахын хамт зарим хэсэг нь нүүдэлчдийн онцлог бүхий хот суурин байгуулж, хагас суурин байдлаар аж төрж ирсэн билээ.

Хот байгуулалт болон барилга архитектурын хөгжил нь хоорондоо салшгүй холбоотой бөгөөд тэдгээр нь хүмүүс орон байр, байшин барилга барьж улмаар олноор

[22] [22] В.Мөнхбаяр. Докторын зэрэг горилох судалгааны ажил. 2012 он

суурьшмал байдалтай амьдарч түүнийгээ зохион байгуулах хөгжлийн үйл явцтай нягт холбоотой аж.

Нүүдлийн соёл иргэншлийн нэг онцлог бол эхний нүүдлийн буюу зөөврийн эсвэл суурин гэсэн хоёр маягаар хот суурин байгуулан амьдарч байсанд оршино.

Нүүдэлчин аймгуудын хаад өргөө гэр байгуулан нэг нутагт тодорхой хугацаанд амьдарч байсан учир түүний орчин тойронд суурьшмал байдал бий болж нүүдлийн хот суурин үүсч хөгжиж байсан байна.

Монголын нутаг дахь нүүдэлчдийн нийгэм, төр, улсын хөгжлийн түүхтэй уялдан хот байгуулалт, барилг архитектурын хөгжил нь зарим үед идэвхжин цэцэглэж, зарим үед зогсонги байдалд орж буурах зэргээр жигд бус явж ирсэн билээ.

Монгол нутагт анхны төрт улс гүрэн бий болсон цагаас эдүгээг хүртлэх хот байгуулалт, барилга архитектурын түүхэн хөгжлийг эрдэмтэн судлаачид ерөнхийд нь дараах 5 үе шатад хуваадаг байна. Үүнд:

1. Монголын эзэнт гүрний өмнөх буюу Феодалын байгууллын өмнөх үе (МЭӨ III зуунаас МЭ XII зуун хүртэл)
2. Монголын эзэнт гүрний болон Феодалын бутралын үе (XIII-XVII зуун)
3. Манжийн дарлалд байсан он жилүүд (XVII зуун 1911 он)
4. Тусгаар тогтнолоо олохын хамт 1921 оны ардын хувьсгал ялж, ардчилсан болон социалист үзэл санааг хэрэгжүүлж байсан он жилүүд (1911-1990)
5. Ардчилал, зах зээлийн замд орсон үе (1990 оноос)
6. Дээр дурдсан үе шат бүрт Монголын хот байгуулалт, барилга архитектур нь ялгарах онцлог шинжүүдтэй байсан боловч тэдгээр нь үндэсний хэв шинжүүдийг агуулж иржээ.
7. Монгол нутагт үүсэн бий болсон эртний хотуудыг цэрэг, засаг захиргааны, худалдаа арилжааны, соёл, шашны төвүүд гэж ангилж болно. Гэхдээ зарим хот эдгээр шинжүүдийг хамтад нь багтаах нь олонтаа.

Хот байгуулалт, барилга архитектурын хөгжил, түүх нь хүмүүсийн анхны орон байр, барилга барьж байсан арга хэлбэртэй салшгүй холбоотой. Иймд монголын хот байгуулалт, барилга архитектурын хөгжилд Төв Азийн нүүдэлчдийн түгээмэл орон сууц болох гэр өөрийн өвөрмөц нөлөөг үзүүлсээр иржээ.

Монголын нутаг дахь нүүдэлчдийн нийгэм, төр, улсын хөгжлийн түүхтэй уялдан хот байгуулалт, барилга архитектурын хөгжил нь зарим үед идэвхжин цэцэглэж, зарим үед зогсонги байдалд орж буурах зэргээр жигд бус явж ирсэн билээ. Монгол нутагт үүсэн бий болсон эртний хотуудыг цэрэг, засаг захиргааны, худалдаа арилжааны, соёл, шашны төвүүд гэж ангилж болно. Гэхдээ зарим хот эдгээр шинжүүдийг хамтад нь багтаах нь олонтаа.

**Эртний хотын турь, хэрэм, балгасын тархац аялал жуулчлалын бүс нутгаар**

| **№** | **Аймаг, хотын нэр** | **Сум, хотын нэр** | **Үл хөдлөх түүх, дурсгалын нэр** |
|---|---|---|---|
| | | **Төвийн бүс** | |
| 1 | Архангай | Хотонт сум | Дойтын толгойн туйр |
| 2 | | | Хар балгас |
| 3 | | Эрдэнэмандал сум | Хар Хул хааны балгас |
| 4 | Булган | Хутаг-Өндөр сум | Байбалык хот |
| 5 | | Дашинчилэн сум | Хар бухын балгас |
| 6 | | | Цогтын цагаан байшин |
| 7 | | | Чин толгойн балгас |
| 8 | Дархан-Уул | Орхон сум | Цантын эртний хотын туйр |
| 9 | Дорноговь | Иххэт сум | Олон байшин |
| 10 | | | Хэсэг байшин |
| 11 | Дорнод | Цагаан-Овоо сум | Тогоонтөмөр хааны Барс хот-3 |

| | | | |
|---|---|---|---|
| 12 | | | Хэрлэн барс хот |
| 13 | Дундговь | Дэрэн сум | Тахилын усны суурин |
| 14 | | Сайхан-Овоо сум | Шаазан хот |
- ☺ Бүх аялагчдын (40,6%) нь өөрийн Монголд хийсэн аялал нь өөрийнх нь хүсэж хүлээсэн хэмжээнд нь маш сайн хүрсэн, (46,2%) нь хүсэн хүлээсэн хэмжээнд нь хүрсэн гэж үзжээ.
- ☺ Аялагчдын ихэнх нь Монголд хийсэн аялалаа "*онц*" гэж (43,1%), "сайн" гэж (55,4%) нь гэж дүгнэжээ.
- ☺ Монголд хийсэн аялалын нөхцөл, үзмэр, үйлчилгээний талаар өгсөн үнэлгээндээ "нүүдлийн соёл, аж ахуй" (43,7%), "нутгийн иргэдийн найрсаг байдал" (40,2%) "тур операторын үйлчилгээ" (31,4%), " хөтөчийн үйлчилгээ" (30,8%)нд хамгийн сэтгэл ханамжтай байсан.
- ☺ Франц, АНУ, Италичууд хамгийн эерэг үнэлгээг өгсөн байна
- ☺ Бүх аялагчдын (61,6%) Монгол оронд дахин зочлох магадлал өндөр тийм гэж хариулсан байна.
- ☺ Бүх аялагчдын (81,6%) Монгол оронд ирж аялахыг бусдад зөвлөнө гэж хариулсан нь 2005 оны судалгааны үр дүнгээс 5%иар илүү байгаа бөгөөд тэднийг Франц (89%), италчиуд (81%)иар тэргүүлжээ.
- ☺ Багц аялалын дундаж үнэ 2548 ам доллар, аялалын дундаж хоног нь 13,4 хоног, хоногийн дундаж зардал нь 190 ам доллар байв. Энд олон улсын нислэгийг оруулаагүй зөвхөн Монгол зарцуулж буй зардал юм. АНУ-н жуулчдын өдрийн дундаж зардал нь 302 ам доллар буюу хамгийн их байсан бол харин Германы жуулчид хамгийн бага буюу 133,4 ам долларыг өдөрт зарцуулжээ.
- ☺ Бие даан аялалаа өөрөө зохион байгуулсан аялагчдын дундаж зардал нь 2018 ам доллар, аялалын дундаж хоног нь 16,7 хоног өдрийн дундаж зардал 120 ам доллар байв.
- ☺ Бие даан аялалаа өөрөө зохион байгуулсан гэж хариулсан жуулчдаас үүргэвчтэй аялагчид буюу *backpackers* , хямд зардалаар аялагчид буюу *budget travelers* гэж өөрийгөө тодорхойлсон аялагчдын зардалыг тусад нь бодсон бөгөөд үүргэвчтэй аялагчид 1811 ам долларыг зарцуулж, 20,8 хоног аялаж өдрийн дундаж зардал нь 77,4 ам доллар байжээ. Хямд зардалаар аялагчид 1917 ам доллар зарцуулж 19,2 хоног аялажээ.
- ☺ Бие даан аялалаа зохион байгуулсан германиуд 74,5 ам доллар, франц 94,7 ам доллар, Солонгос 120,5 ам доллар, Япон 165 ам долларыг өдөрт дунджаар зарцуулжээ.
- ☺ Бие даан аялалаа зохион байгуулсан аялагчид зочид буудал буюу орон байранд 294 ам доллар буюу нийт зардалын (27%), дотоодын нислэгт 236 ам доллар буюу 22%, орон нутгийн тээвэрт 158 ам доллар буюу (15%) зарцуулжээ.
- ☺ Үүргэвчтэй аялагчид орон нутгийн тээвэрт 168 ам доллар буюу нийт аялалын зардалын (22%), жуулчны орон байранд 155 ам доллар буюу (20%), орон нутгийн нислэгт 137 ам доллар буюу (18%) тус тус зарцуулжээ.
- ☺ Монгол орны талаарх хамгийн их сэтгэлийг нь хөдөлгөсөн зүйлс нь "*үзэсгэлэнтэй сайхан байгаль, өргөн уудам тал нутаг, хөдөө нутаг, өндөр уулс, тунгалаг сайхан нуур, хэн ч байхгүй эзгүй тал хээр*" гэж 812 аялагч хариулсан байна.
- ☺ "*Нүүдэлчин Монголын соёл, малчин ахуй, монгол гэр, малчин айлд зочлох, малчин айлд хонох гэсэн Монгол ахуй амьдрал, зан заншил, Монгол хоол*" хамгийн сайхан сэтгэгдэл үлдээсэн хэмээн 631 аялагч хариулжээ.
- ☺ "*Монголчуудын найрсаг зочломтгой зан, нөхөрсөг итгэмтгий байдал, амархан найз болдог чадвар*" нь сэтгэлд нь хүрсэн гэж 502 аялагч хариулсан байна.

***Сөрөг үзүүлэлтүүд***

- ☹ Жуулчид Монголд хийсэн аялалын нөхцөл, үзмэр, үйлчилгээний талаар өгсөн үнэлгээндээ “орон нутгийн тээвэр” (15,3%), “дотоодын нислэгийн үйлчилгээ” (5,3%), “аялалын аюулгүй байдал” (4,1%) хамгийн таагүй үнэлгээг өгчээ.
- ☹ Монголд аялсандаа Хятад, Гонг Конг, Солонгосын жуулчид хамгийн нааштай бус үнэлгээг өгсөн байна
- ☹ АНУ-н жуулчдын өдрийн дундаж зардал нь 302 ам доллар буюу хамгийн их байсан бол харин Германы жуулчид хамгийн бага буюу 133,4 ам долларыг өдөрт зарцуулжээ.
- ☹ Бие даан аялалаа өөрөө зохион байгуулсан гэж хариулсан жуулчдаас үүргэвчтэй аялагчид буюу *backpackers* , хямд зардалаар аялагчид буюу *budget travelers* гэж өөрийгөө тодорхойлсон аялагчдын зардалыг тусад нь бодсон бөгөөд үүргэвчтэй аялагчид 1811 ам долларыг зарцуулж, 20,8 хоног аялаж өдрийн дундаж зардал нь 77,4 ам доллар байжээ. Хямд зардалаар аялагчид 1917 ам доллар зарцуулж 19,2 хоног аялажээ.
- ☹ Асуулганд оролцсон нийт 596 хүн *“Улаанбаатар хотын замын түгжээ”* хамгийн таагүй зүйл байсан ба зарим нь хот дотор нэг газраас нөгөө газарруу очих гэж 3-4 цаг түгжирсэн нь хамгийн таагүй сэтгэгдэл төрүүлсэн гэжээ.
- ☹ 262 аялагч аялалын явцад хамгийн хэцүү байсан асуудал бол ариун цэврийн өрөө байсан гэжээ. Улаанбаатар хотод нийтийн бие засах газар байхгүй байсан нь маш бохир заваан, ариун цэврийн цаасгүй, бие засах газаргүй учир юм уухгүй явахыг хичээсэн гэж хариулжээ.
- ☹ Улаанбаатар хотыг зохион байгуулалтгүй, бохир заваан, бороотой үед ус зайлуулагч байхгүй, үйлчилгээний салбарын хөгжилгүй, гудамж нь өөрийн гэсэн хүний сэтгэлийг татах зүйлгүй, хог хаягдал ихтэй, гуйлгачин хүүхдүүдтэй мөн зурагаа зарах гэсэн худалдаачид нь ядаргаатай, гудамжны нэр хаяг байхгүй гудамжаар нь алхахад аюултай санагдсан гэж 159 аялагч хариулжээ
- ☹ Нийт 105 хүн таксины жолооч нарыг залилаж худлаа хэлэн мөнгө авдаг жишээбэл нисэх буудалаас зочид буудал ороход 45000 төгрөг авсан, км хэмжигч байхгүй, тасалбар өгдөггүй, бохир муухай үнэртэй, зогсоол байхгүй дуудахаар ирдэггүй, хэт хурдан авч давхидаг, хамгаалалтын бүсгүй, англи хэл огт мэддэггүй маш бүдүүлэг аюултай гэжээ.

## Өрсөлдөгчдийн судалгаа

Монгол улс 2011 оны байдлаар нэг хүнд ногдох ДНБ оны үнээр 3886.7 мян.төг, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 1751.9 мян. төгрөгт, Үндэсний нийт орлого (ҮНО) оны үнээр 3557.3 мян.төг, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 1603.4 мян.төгрөгт хүрлээ. Дэлхийн банкны атласын аргаар тооцсон нэг хүнд ногдох ДНБ 2011 онд оны үнээр 2562 ам.доллар, ҮНО 2345 ам.долларт хүрч байна.[31] Энэ үзүүлэлт өсөлттэй харагдаж байгаа хэдий ч манай улс Дэлхийн банкны орлогын ангиллаар бага-дунд орлоготой орны ангилалд байна.[32]

Дэлхийн эдийн засгийн форумаас гаргасан “Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан”-д Монгол улс 2009 онд 133 орноос 117-д, 2010 онд 142 орноос 99-д, 2011 онд 142 орноос 96-д эрэмблэгдэж, тодорхой хэмжээгээр байр урагшилсан байна.[33] /Уг судалгаа 142 орныг хамруулан, 111 үзүүлэлтээр үүний 70 хувийг асуулга судалгаагаар, 30 хувийг статистик үзүүлэлтийг судалж гаргадаг байна./

Мөн Дэлхийн банкнаас явуулсан “Бизнес эрхлэхүй” судалгаагаар Монгол улс 2010 онд 182 орноос 63-д, 2011 онд 183 орноос 89-д, 2012 онд 183 орноос 86-д эрэмблэгдсэн байна. /Уг судалгаа 183 орныг хамруулан, 10 үзүүлэлтээр хэмждэг./

Дэлхийн эдийн засгийн форумаас гаргасан “Аялал жуулчлалын өрсөлдөх чадварын тайлан”-д Монгол улс 2009 онд 133 орноос 105-д, 2011 онд 139 орноос 101-д эрэмблэгдэж байр ухарсан байна.[34] /Уг судалгаа 3 бүлэг, 14 дэд бүлэг 75 шалгуур үзүүлэлтээр судалж гаргадаг байна./

Уг тайлангаас үзвэл Монгол улс байгаль орчны тогтвортой хөгжил (138), тээврийн дэд бүтэц (133), боловсрол болон сургалтын үйл ажиллагаа (105) гэсэн үзүүлэлтүүдэд хамгийн муу оноог[35] авсан байна.

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн гаргасан “Монгол Улсын Өрсөлдөх Чадварын Тайлан”-д Монгол улс 2010 онд 15 орноос 24 оноогоор 14-д, 2011 онд 15 орноос 28 оноогоор 15-д эрэмблэгдэж, оноо ахисан ч байр ухарсан байна.

“Монгол Улсын Өрсөлдөх Чадварын Тайлан”-д дурьдсанаар ХАМГИЙН САЙН 20 үзүүлэлтэд АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛААС ОЛСОН ОРЛОГО /ДНБ-д эзлэх хувь / гэсэн үзүүлэлт орсон нь бахархууштай.[36]

Аливаа хөгжиж буй орон өрсөлдөх стратегийн сонголтоо хийгээгүй тохиолдолд ядуурлаас гарахад ихээхэн төвөгтэй байх болно. Саяхныг болтол зөвхөн байгалийн баялагтаа тулгуурлан амьдарч байсан улсууд бүс нутгийнхаа болон дэлхийн зах зээлд өрсөлдөх стратегиа зөвөөр тодорхойлон амжилт олох боллоо. Үүний нэг тод жишээ бол Персийн буланд оршдог, гурван сая орчим хүн амтай, газрын тосны арвин нөөцтэй Арабын Нэгдсэн Эмирт Улс (АНЭУ) юм. Энэ улс байгалийн баялгаасаа үл хамааран хөгжих зорилго тавин, бусад олон салбарт өрсөлдөх давуу талаа тодорхойлон хэрэгжүүлсэн. Үүний дүнд, сүүлийн арав хүрэхгүй жилийн дотор дэлхийн агаарын тээврийн тэргүүлэгчидтэй өрсөлдөх болсон “Эмирэйтс” компанийг бий болгож, Дубай хотыг бүс нутгийнхаа санхүү, хөрөнгө оруулалт, мэдээллийн технологийн төв болгон, Америкийн их сургуулиудын салбарууд, чинээлэг жуулчдыг татдаг амралтын газрууд, татваргүй дэлгүүрийн сүлжээг бий болгожээ. Өөрөөр хэлбэл, АНЭУ ирээдүйд газрын тосноосоо үл хамааран тогтвортой хөгжих нөхцөлөө бүрдүүлж чадсан байна.[37]

---

[31] Монголын Үндэсний Статистикийн Хороо, “Статистикийн эмхэтгэл-2011”, Улаанбаатар, 2012, 36-р тал

[32] http://data.worldbank.org/about/country-classifications/country-and-lending-groups

[33] Д.Жаргалсайхан, “Өрсөлдөх чадварыг сайжруулах шинэчлэлийн бусад боломж”, “Бизнесийн орчныг сайжруулах замын зураглал боловсруулах нь” сэдэвт хурал, 2012.08.16, Улаанбаатар хот, 4-р тал

[34] The Travel &Tourism Competitiveness Report 2011, World Economic Forum, Geneva, Switzerland, 2011, 8-р тал

[35] The Travel &Tourism Competitiveness Report 2011, World Economic Forum, Geneva, Switzerland, 2011, 277-р тал

[36] Монгол Улсын Өрсөлдөх Чадварын Тайлан, 2012, 12-р тал

[37] http://www.tsagtur.mn/index.php?option=com_content&view=article&id=129:2009-08-19-09-48-53&catid=59:ieeoeyadaeeei-aoeai

Дэлхийн Аялал Жуулчлалын Байгууллагаас эрхлэн гаргадаг жил бүрийн тайлангаас үзвэл олон улсын аялал жуулчлалын зах зээлд дотогшоо чиглэсэн аяллын тоог үзүүлэлт сүүлийн жилүүдэд өссөн дүнтэй гарсан байна. Тухайлбал 2010 онд 940[38] сая жуулчин хүлээн авч 2009 оныхоос 7 %-иар өссөн ба олсон орлого нь 919 тэрбум америк долларт хүрч 2009 оныхоос 5 %-иар өссөн байна. Зүүн Ази-Номхон далайн бүс нутгийн үзүүлэлт 204 сая жуулчин аяласан нь 2009 оныхоос 13 %-иар өсч, зах зээлийнхээ 22 %-ийг эзэлсэн ба олсон орлого нь 249 тэрбум америк долларт хүрч, зах зээлийнхээ 27 %-ийг эзэлж байна.

2011 онд 982[39] сая жуулчин хүлээн авч 2010 оныхоос 4.6 %-иар өссөн ба олсон орлого нь 1 их наяд 30 тэрбум америк долларт хүрч 2010 оныхоос 3.8 %-иар өссөн байна. Зүүн Ази-Номхон далайн бүс нутгийн үзүүлэлт 217 сая жуулчин аяласан нь 2010 оныхоос 6 %-иар өсч, зах зээлийнхээ 22 %-ийг эзэлсэн ба олсон орлого нь 289 тэрбум америк долларт хүрч, зах зээлийнхээ 28 %-ийг эзэлж байна.

Үндэсний шинэтгэлийн хорооноос Монгол улсын өрсөлдөх чадварыг тодорхойлоходоо "Глобал өрсөлдөх чадвар (хөрш, ойр зэргэлдээ 7 орноор)" гэсэн үзүүлэлтдээ Япон, Солонгос, Хятад, ОХУ, Казакстан, Киргизстан гэсэн орнуудыг сонгон, хувиар илэрхийлэх олон улсын аргачлалаар тооцсон байна. Монгол улс Казакстаны дараа 6-р байранд орж, Киргизстаныг ардаа орхисон байна.[40]

Иймд Монгол орны аялал жуулчлалын зах зээлийн гол өрсөлдөгчдөөр ОХУ, Хятад, Казакстан улсыг сонгон авсан болно. Мөн дотогшоо чиглэсэн аялалын /inbound tourism/ тоон үзүүлэлтийг гол статистик суурь болгож, өрсөлдөх чадварыг тодорхойлон, баримталбал зохих стратегиудыг боловсруулахыг хичээсэн болно.

*Хүснэгт 1. Хөрш орнуудын болон Монгол улсын хүлээн жуулчдын тоо болон орлогын үзүүлэлт*[41]

| Улс | Хүлээн авсан жуулчдын тоо, мян | | | | | | Орлого, сая америк доллар | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2009 | 2010 | 2011 | Өөрчлөлт, % 2009-2010 | Өөрчлөлт, % 2010-2011 | Зах зээлд эзлэх хувь | 2009 | 2010 | 2011 | Зах зээлд эзлэх хувь |
| Зүүн Ази-Номхон далайн бүс | 98,017 | 111,508 | 115,779 | 13.8 | 3.8 | 53.4 | 101,627 | 128,579 | 143,051 | 49.4 |
| Хятад | 50,875 | 55,664 | 57,581 | 9.4 | 3.4 | 26.5 | 39,675 | 45,814 | 48,464 | 16.7 |
| Монгол улс | 411 | 456 | 456* | 10.8 | 0.0* | 0.2 | 235 | 244 | 218 | 0.1 |
| Төв болон Зүүн Европ | 92,619 | 95,676 | 103,457 | 3.3 | 8.1 | 47.7 | 47,948 | 48,094 | 56,072 | 19.4 |
| ОХУ | 19,420 | 20,271 | 22,686 | 4.4 | 11.9 | 10.5 | 9,366 | 8,830 | 11,398 | 3.9 |
| Казакстан | 3,118 | 3,393 | 4,093 | 8.8 | 20.6 | 1.9 | 963 | 1,005 | 1,209 | 0.4 |

** Тайлбар: Монгол улсын хувьд статистик мэдээгээ дутуу өгсөн байгаа бөгөөд хилээр орж ирсэн гадаадын зорчигчдын тоо 2011 онд 460360*[42] *болж өмнөх оныхоос 0.93 хувиар өссөн байна.*

[38] UNWTO Annual Report: A year of recovery 2010, Madrid, Spain, 2011, 7-р тал
[39] UNWTO Annual Report: A year of recovery 2011, Madrid, Spain, 2012, 8-р тал
[40] Ч.Хашчулуун, Р.Анхбаатар "Монгол Улсын 2010-2015 оны дунд хугацааны хөгжлийн стратеги-өрсөлдөх чадварыг дээшдүүлэх асуудал", Монгол Улсын Засгийн газар -Хөгжлийн түншүүдийн хамтарсан техникийн уулзалт, 2011.3. 4, 6-р тал
[41] UNWTO Tourism Highlights 2012 Edition, Madrid, Spain, 2012, 10-р тал
[42] Монголын Үндэсний Статистикийн Хороо, "Статистикийн эмхэтгэл-2011", Улаанбаатар, 2012, 293-р тал

**CPM** “Competitive Profile Matrix” матриц буюу
Өрсөлдөөнийг тодорхойлогч матриц

Уг матриц салбарын гол өрсөлдөгчид ба салбарыг амжилтанд хүргэх хүчин /Critical Success Factors/ зүйлсүүдийг үнэлж, харьцуулсан үзүүлэлтийг илэрхийлнэ.

*Хүснэгт 4. **CPM** матриц*

| № | Хүчин зүйлс | Жин | Монгол улс | | Өвөр Монголын Өөртөө засах орон | | Эрхүү муж | | Казакстан улс | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Балл | Жинлэгдсэн оноо | Балл | Жинлэгдсэн оноо | Балл | Жинлэгдсэн оноо | Балл | Жинлэгдсэн оноо |
| 1 | Аялал жуулчлалын нөөц | 0.2 | 4 | 0.8 | 4 | 0.8 | 4 | 0.8 | 4 | 0.8 |
| 2 | Хөрөнгө оруулалт | 0.12 | 1 | 0.12 | 4 | 0.48 | 4 | 0.48 | 3 | 0.36 |
| 3 | Институцийн орчин | 0.05 | 2 | 0.1 | 2 | 0.1 | 2 | 0.1 | 2 | 0.1 |
| 4 | Нэр хүнд | 0.05 | 1 | 0.05 | 3 | 0.15 | 2 | 0.1 | 3 | 0.15 |
| 5 | Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ | 0.08 | 1 | 0.08 | 3 | 0.24 | 2 | 0.16 | 2 | 0.16 |
| 6 | Дэд бүтцийн хөгжил | 0.2 | 1 | 0.2 | 2 | 0.4 | 2 | 0.4 | 2 | 0.4 |
| 7 | Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар | 0.15 | 3 | 0.45 | 3 | 0.45 | 3 | 0.45 | 3 | 0.45 |
| 8 | Сурталчилгаа | 0.15 | 1 | 0.15 | 3 | 0.45 | 2 | 0.3 | 2 | 0.3 |
| | | 1 | | 1.95 | | 3.07 | | 2.79 | | 2.72 |

**CPM** Матрицийн үнэлгээнээс гарсан дүгнэлт
Амжилтанд хүргэх хүчин зүйлсийг тодорхойлохын тулд **EFE** болон **IFE** матрицуудаас гарсан үнэлгээг харгалзан үзсэн болно. Өрсөлдөгчдийг тодорхойлохдоо хөрш орнууд, мужийг сонгосон болно. Өрсөлдөх чадварын оноо Монгол улсынх 1.95 байгаа нь хөрш орнуудтай харьцуулахад чадвар муу байгааг харуулж байна. Монгол орны хувьд гол өрсөлдөгч нь Өвөр Монголын Өөртөө засах орон бөгөөд өрсөлдөх чадварын оноо нь 3.07 байна. Амжилтанд хүрэхэд хамгийн чухал нь сурталчилгаагаа амжилттай хийж, дэд бүтцээ хөгжүүлснээр зах зээлийн багтаамж нэмэгдэх болно.

**SPACE** “Strategic Position and Action Evaluation Matrix” Стратегийн байрлал болон тухайн байгууллагын одоо баримталж буй стратегийг тодорхойлох матриц

Энэхүү матриц нь салбарын одоо баримталж буй стратегийг тодорхойлно.

*Хүснэгт 6. **SPACE** матриц*

| Дотоод стратегийн байрлал | | Гадаад стратегийн байрлал | |
|---|---|---|---|
| *Стратегийн үзүүлэлтүүд* | Оноо | *Стратегийн үзүүлэлтүүд* | Оноо |
| **Санхүүгийн чадавхи** | | **Орчны тогтворжилт** | |
| Хөрөнгө оруулалтын өгөөж | 2 | Технологийн өөрчлөлт | -1 |
| Хөшүүрэг | 3 | Инфляцийн түвшин | -4 |
| Хөрвөх чадвар | 4 | Эрэлтийн өөрчлөлт | -3 |
| Ажлын капитал | 4 | Өрсөлдөх бүтээгдэхүүний үнэ | -3 |
| Бэлэн мөнгөний урсгал | 5 | Зах зээлд нэвтрэх саад | -1 |
| | | Өрсөлдөөний дарамт | -2 |
| | | Зах зээлээс гарахад хялбар байх | -2 |
| *Дундаж оноо* | **3.6** | *Дундаж оноо* | **-2.3** |
| *Стратегийн үзүүлэлтүүд* | Оноо | *Стратегийн үзүүлэлтүүд* | Оноо |
| **Өрсөлдөх давуу тал** | | **Бизнесийн чадавхи** | |
| Зах зээлд эзлэх хувь | -5 | Өсөлтийн боломж | 5 |
| Бүтээгдэхүүний чанар | -3 | Ашгийн боломж | 5 |

| | | | |
|---|---|---|---|
| Бүтээгдэхүүний амьдралын мөчлөг | -5 | Санхүүгийн тогтворжилт | 2 |
| Хэрэглэгчийн итгэл | -2 | Технологийн ололт | 3 |
| Технологийн шинэчлэл | -2 | Нөөц ашиглалт | 3 |
| Нийлүүлэгчдэд тавих хяналт | -6 | Бүтээмж, хүчин чадал ашиглалт | 2 |
| *Дундаж оноо* | **-3.8** | *Дундаж оноо* | **3.3** |

*Зураг 2.* ***SPACE*** *матриц*




**SPACE** Матрицийн үнэлгээнээс гарсан дүгнэлт

Монгол орны аялал жуулчлалын салбар “Хамгаалах стратеги” баримтлан үйл ажиллагаа явуулж байна.

Тогтворжих стратегид хүрэхийн тулд юуны өмнө санхүүгийн чадавхиа нэмэгдүүлэх бөгөөд энэ хүрээнд хөрөнгө оруулалт, дэд бүтцийн хөгжлийг нэмэгдүүлэх нь чухал.

Эрчимжих стратегид хүрэхийн тулд бизнесийн чадавхиа нэмэгдүүлэх бөгөөд энэ хүрээнд институцийн орчныг сайжруулах, нөөц ашиглалтаа нэмэгдүүлж бүтээмжийг өсгөх хэрэгтэй.

Ингэснээр аялал жуулчлалын салбарын эдийн засгийн чадавхи бэхжиж Өрсөлдөх стратегид хүрэх болно.

**BCG** "Boston Consulting Group Matrix"
Бостоны зөвлөх группын матриц

Монгол улс нь Зүүн Ази-Номхон далайн бүсийн аялал жуулчлалын зах зээлийн 0.1[43] хувийг эзэлж байгаа ба аялал жуулчлалаас оруулж буй орлого нь ДНБ-ний 4 орчим[44] хувийг эзэлж байна.

*Зураг 3.* Бостоны зөвлөх группын матриц




**BCG** Матрицийн үнэлгээнээс гарсан дүгнэлт

Монгол орны дотогшоо чиглэсэн аялалын хувьд "Асуултын тэмдэг" бүхий байршилд оршиж байна. Эрчимжих стратегийг баримталснаар "Саалийн үнээ" бүхий байршилд хүрэх бөгөөд Өрсөлдөх стратегийг баримталснаар "Од" бүхий байршилд хүрэх болно.

Энэхүү матрицийн шинжилгээг зөвхөн дотогшоо чиглэсэн аялалын үзүүлэлтээр байгуулсан. Монгол улсын статистик мэдээнээс гадагшаа чиглэсэн аялал болон дотоодын аялал жуулчлалын тоон үзүүлэлт олдохгүй байгаа нь шинжилгээг хязгаарлах хүчин зүйл болсон.

Иймд цаашид жуулчдын бүртгэл тооцоолол, статистик мэдээг нэгтгэн боловсруулах асуудалд анхаарах хэрэгтэй байна.

---

[43] UNWTO Tourism Highlights 2012 Edition, Madrid, Spain, 2012, 10-р тал
[44] http://news.zindaa.mn/

**IE** “Internal-External Matrix”
Гадаад болон дотоод хүчин зүйлсийн матриц

*Хүснэгт 7. **IE** матриц*

| Дотоод хүчин зүйлсийн үнэлгээний баллын дүн | Гадаад хүчин зүйлсийн үнэлгээний баллын дүн | | | |
|---|---|---|---|---|
| | | Хүчтэй 3.0-4.0 | Дунд 2.0-2.99 | Сул 1.0-1.99 |
| | Их 3.0-4.0 | **11 / 63%** | | |
| | Дунд 2.0-2.99 | | | |
| | Бага 1.0-1.99 | | | |

**IE** Матрицийн үнэлгээнээс гарсан дүгнэлт

Гадаад болон дотоод хүчин зүйлсийн үнэлгээний баллын дүнгийн нэгтгэлийн 63 % нь буюу 11 үзүүлэлт Өсөлтийн стратегийн  талбарт оногдож байна. Энэ нь аялал жуулчлалын салбарын урт хугацааны стратегийн бодлогууд хэрэгжих боломжтойг илтгэж байна.

3-р үе: **QSPM** *матриц, түүнд хийсэн үнэлэлт дүгнэлт*

Энэхүү матрицаар стратегийн боломжит хувилбарыг сонгож,  үнэлэлт өгөхөд оршино.

*Хүснэгт 8. **QSPM** матриц*

| № | Хүчин зүйлс | жин | Стратегийн боломжит хувилбарууд | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | SO стратеги | | ST стратеги | | WO стратеги | | WT стратеги | |
| | | | балл | оноо | балл | оноо | балл | оноо | балл | оноо |
| **Дотоод хүчин зүйлс** | | | | | | | | | | |
| **Strengths: Давуу тал** | | | | | | | | | | |
| 1 | Аялал жуулчлал идэвхитэй хөгжиж буй орнууд, бүс нутгуудтай хиллэдэг | 0.08 | 4 | 0.32 | 2 | 0.16 | 1 | 0.08 | 2 | 0.16 |
| 2 | Гадаад харилцааны нээлттэй бодлого баримталдаг | 0.04 | 4 | 0.16 | 1 | 0.04 | 1 | 0.04 | 2 | 0.08 |
| 3 | Байгалийн унаган төрхөө харьцангуй сайн хадгалж үлдсэн | 0.04 | 2 | 0.08 | 1 | 0.04 | 4 | 0.16 | 2 | 0.08 |
| 4 | Нүүдлийн соёл иргэншлийг хадгалж үлдсэн | 0.08 | 4 | 0.32 | 1 | 0.08 | 4 | 0.32 | 3 | 0.24 |
| 5 | Дэлхий нийтэд шинээр танигдаж байгаа | 0.02 | 4 | 0.08 | 1 | 0.02 | 2 | 0.04 | 3 | 0.06 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Түүх, соёлын аялал жуулчлалын нөөц сайтай | 0.1 | 2 | 0.2 | 2 | 0.2 | 4 | 0.4 | 4 | 0.4 |
| 7 | Эко аялал жуулчлалын нөөц сайтай | 0.1 | 2 | 0.2 | 2 | 0.2 | 4 | 0.4 | 4 | 0.4 |
| 8 | Дотоодын болон гадагшаа чиглэсэн аялагчдын тоо нэмэгдэж байгаа | 0.02 | 3 | 0.06 | 2 | 0.04 | 2 | 0.04 | 3 | 0.06 |
| **Weaknesses: Сул тал** | | | | | | | | | | |
| 1 | Улиралаас хамааралтай байдал | 0.06 | 2 | 0.12 | 4 | 0.24 | 2 | 0.12 | 2 | 0.12 |
| 2 | Хууль эрх зүйн орчин одоогийн шаардлагыг хангахгүй | 0.04 | 3 | 0.12 | 2 | 0.08 | 2 | 0.08 | 4 | 0.16 |
| 3 | Дэд бүтцийн хөгжил сул | 0.1 | 4 | 0.4 | 2 | 0.2 | 4 | 0.4 | 4 | 0.4 |
| 4 | Бүтээмж багатай олон тооны тур операторуудтай | 0.06 | 4 | 0.24 | 4 | 0.24 | 2 | 0.12 | 3 | 0.18 |
| 5 | Мэргэжлийн боловсон хүчний давтан мэргэших байдал хангалтгүй | 0.04 | 2 | 0.08 | 3 | 0.12 | 3 | 0.12 | 4 | 0.16 |
| 6 | Үйлчилгээний чанарын удирдлага сул | 0.1 | 2 | 0.2 | 3 | 0.3 | 2 | 0.2 | 4 | 0.4 |
| 7 | Тур операторууд аялал зохион байгуулалтаараа төрөлжөөгүй, бүтээгдэхүүний нэр төрөл цөөхөн | 0.08 | 4 | 0.32 | 4 | 0.32 | 4 | 0.32 | 4 | 0.32 |
| 8 | Цахим бизнесийн нэвтрэлт сул, хамгаалалт хязгаарлагдмал | 0.04 | 1 | 0.04 | 4 | 0.16 | 2 | 0.08 | 3 | 0.12 |
| **Бүгд** | | **1** | | 2.94 | | 2.44 | | 2.92 | | 3.34 |
| **Гадаад хүчин зүйлс** | | | | | | | | | | |
| **Opportunities: Боломж** | | | | | | | | | | |
| 1 | Аялал жуулчлалын салбарыг тэргүүлэх чиглэлээ болгосон төр засгийн эерэг бодлого | 0.04 | 2 | 0.08 | 2 | 0.08 | 2 | 0.08 | 2 | 0.08 |
| 2 | Гадаадын хөрөнгө оруулалгчдын сонирхол нэмэгдэж байгаа | 0.04 | 4 | 0.16 | 2 | 0.08 | 2 | 0.08 | 4 | 0.16 |
| 3 | Дэлхийн Аялал жуулчлалын салбарын эдийн засгийн тогтвортой өсөлт | 0.04 | 2 | 0.08 | 1 | 0.04 | 2 | 0.08 | 3 | 0.12 |
| 4 | Монгол орны аялал жуулчлалын салбарын эдийн засгийн тогтвортой өсөлт | 0.04 | 2 | 0.08 | 2 | 0.08 | 4 | 0.16 | 2 | 0.08 |
| 5 | Хөрш орнуудын аялал жуулчлалын зах зээл багтаамж ихтэй | 0.1 | 4 | 0.4 | 2 | 0.2 | 2 | 0.2 | 2 | 0.2 |
| 6 | Дэд бүтцийн шинэ төлөвлөлт, бүтээн байгуулалт хийгдэж буй | 0.1 | 4 | 0.4 | 4 | 0.4 | 4 | 0.4 | 4 | 0.4 |
| 7 | Мэдээлэл холбоо, техник технологийн дэвшилтэт шийдэл, нэвтрэлт хурдан | 0.08 | 1 | 0.08 | 4 | 0.32 | 2 | 0.16 | 2 | 0.16 |
| 8 | Аялал жуулчлалын бизнес нь хөрвөх чадвар, шинэ бизнесийн нэвчих боломж их | 0.04 | 4 | 0.16 | 4 | 0.16 | 4 | 0.16 | 4 | 0.16 |
| **Threats: Аюул** | | | | | | | | | | |
| 1 | Хууль эрх зүйн орчны тогтворгүй байдал, үйлчилгээнд хязгаарлалт | 0.06 | 4 | 0.24 | 2 | 0.12 | 2 | 0.12 | 4 | 0.24 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хийх | | | | | | | | | |
| 2 | Эдийн засгийн хямрал, валютын ханшны хэлбэлзэл, инфляци тогтворгүй | 0.04 | 2 | 0.08 | 2 | 0.08 | 2 | 0.08 | 4 | 0.16 |
| 3 | Аялал жуулчлалын суурь үнэ буурахгүй байх | 0.08 | 4 | 0.32 | 4 | 0.32 | 4 | 0.32 | 4 | 0.32 |
| 4 | Бие даасан болон хямд өртгөөр аялах жуулчдын тоо өсөлттэй байх | 0.06 | 3 | 0.18 | 2 | 0.12 | 4 | 0.24 | 2 | 0.12 |
| 5 | Үйлчилгээний байгууллагуудын багтаамж хангалтгүй | 0.04 | 2 | 0.08 | 3 | 0.12 | 4 | 0.16 | 4 | 0.16 |
| 6 | Аялал жуулчлалын өртгийн сүлжээн дэх нэгжүүдийн чанаргүй үйлчилгээ их, хүлээх хариуцлага төлөвшөөгүй | 0.04 | 3 | 0.12 | 2 | 0.08 | 2 | 0.08 | 4 | 0.16 |
| 7 | Эх газрын эрс тэс уур амьсгал нь аяллын улирлын шинжтэй болгож хязгаарладаг | 0.1 | 2 | 0.2 | 4 | 0.4 | 4 | 0.4 | 2 | 0.2 |
| 8 | Байгаль орчны доройтол, нөөц баялгийн зохисгүй хэрэглээ | 0.1 | 2 | 0.2 | 2 | 0.2 | 4 | 0.4 | 2 | 0.2 |
| **Бүгд** | | **1** | | 2.86 | | 2.8 | | 3.12 | | 2.92 |
| **Жинлэгдсэн онооны нийлбэр** | | **2** | | 5.8 | | 5.24 | | 6.04 | | 6.26 |

**QSPM** Матрицийн үнэлгээнээс гарсан дүгнэлт

Матрицаас гарсан үнэлгээг жагсаавал:

WT стратеги: 6.26 оноо

WO стратеги: 6.04 оноо

SO стратеги: 5.8 оноо

ST стратеги: 5.24 оноо тус тус авсан байна.

Иймд стратегийн бодлого төлөвлөлтийн дунд хугацаанд сул талуудаа давуу тал болгож зах зээлийн боломжийг бүрэн ашиглаж, эрсдлээс сэргийлэх WT болон WO стратеги, урт хугацаанд давуу талуудаа ашиглан зах зээлийн боломжийг бүрэн ашиглаж, эрсдлээс сэргийлэх SO болон ST стратегийг баримтлах нь зүйтэй.

## ПОРТЕРЫН 5 ХҮЧНИЙ ШИНЖИЛГЭЭГЭЭР АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

1. Threat of New Entrants: Зах зээлд нэвтрэх саад **“Бага”**:
- Төрөөс аялал жуулчлалыг эдийн засгийн тэргүүлэх салбар болгосон
- Татварын бодлого
- Шинээр аялал жуулчлалын байгууллага байгуулах зардал харьцангуй бага гэх мэт.
2. Competitive Rivalry between Existing Players: Өрсөлдөөний хүч **“Их”**:
- ОХУ-ын Байгал нуур орчмын аялал жуулчлалын хөгжил
- БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө засах орны аялал жуулчлалын хөгжил
- БНКУ-ын аялал жуулчлалын хөгжил
3. Bargaining Power of Suppliers: Нийлүүлэгчийн зүгээс нөлөөлөх хүч **“Бага”**:
- Гадаадын тур агент, тур оператор
- Дотоодын тур агент, тур оператор
4. Bargaining Power of Customers: Худалдан авагчийн зүгээс нөлөөлөх хүч **“Бага”**:
- Гадаадын түнш тур оператор
- Төрийн болон олон улсын байгууллагууд
- Гадаад болон дотоодын аж ахуйн нэгж
- Гадаадын жуулчин
- Дотоодын амрагч, аялагчид
5. Threat of Substitutes: Орлох бүтээгдэхүүний аюул **“Их”**:
- Гэр бүл, найз нөхдөөр аялах \аялал жуулчлалын байгууллагын үйлчилгээгүйгээр гэр бүлийн шугамаар\
- Байгууллага хамт олноор аялах \аялал жуулчлалын байгууллагын үйлчилгээгүйгээр тухайн байгууллагын шугамаар\
- Бие даасан аялагчид
6. Threat of Complementary products: Нөхөх бүтээгдэхүүний аюул **“Их”**:
- Үйлчилгээний байгууллагууд /тээврийн байгууллагууд, байршуулах хэрэгсэл, зоог ундааны үйлчилгээ, үзмэрийн үйлчилгээ, хөтөч-тайлбарлагчийн үйлчилгээ/
- Тур агент
- Төр, захиргааны үйлчилгээ /виза, гааль, даатгал, эмнэлэг, цагдаа/

*Зураг 4. Портерын 5 хүчний шинжилгээ*

**Баг**

Зах зээлд нэвтрэх саад

- Төрөөс аялал жуулчлалыг эдийн засгийн тэргүүлэх салбар болгосон
- Татварын бодлогоор дэмждэг
- Шинээр аялал жуулчлалын байгууллага байгуулах зардал харьцангуй бага

Нийлүүлэгчийн зүгээс нөлөөлөх хүч

**Баг а**

- Гадаадын тур агент, тур оператор
- Дотоодын тур агент, тур оператор

Өрсөлдөөний хүч

**Их**

- ОХУ-ын Байгал нуур орчмын аялал жуулчлалын хөгжил
- БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө засах орны аялал жуулчлалын хөгжил
- БНКУ-ын аялал

Худалдан авагчийн зүгээс нөлөөлөх хүч

**Баг а**

- Гадаадын түнш тур оператор
- Төрийн болон олон улсын байгууллагууд
- Гадаад болон дотоодын аж ахуйн нэгж
- Гадаадын жуулчин
- Дотоодын амрагч, аялагчид

**И х**

Орлох бүтээгдэхүүний аюул

- Гэр бүл, найз нөхдөөр аялах \аялал жуулчлалын байгууллагын үйлчилгээгүйгээр гэр бүлийн шугамаар\
- Байгууллага хамт олноор аялах \аялал жуулчлалын байгууллагын үйлчилгээгүйгээр тухайн байгууллагын шугамаар\
- Бие даасан аялагчид

**И х**

Нөхөх бүтээгдэхүүний аюул

- Үйлчилгээний байгууллагууд /тээврийн байгууллагууд, байршуулах хэрэгсэл, зоог ундааны үйлчилгээ, үзмэрийн үйлчилгээ, хөтөч-тайлбарлагчийн үйлчилгээ/
- Тур агент
- Төр, захиргааны үйлчилгээ /виза, гааль, даатгал, эмнэлэг, цагдаа/

**Портерын 5 хүчний шинжилгээнээс** гарсан дүгнэлт

Орлох болон нөхөх бүтээгдэхүүний аюул их байгаа нь аялал жуулчлалын салбарыг дэмжих институцын орчин хангалтгүй байна гэж үзэхээр байна. Иймд олон улсын зах зээлд Монгол орны өрсөлдөөний хүч сул, хөрш орнуудынх их байна.

Монгол орны аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварыг тодорхойлохдоо шинжилгээний схем хоёрыг боловсруулж, 8 матрицийг байгуулан үнэлэлт дүгнэлт өгсөн болно.

1. **PESTLE** шинжилгээгээр өрсөлдөөний орчныг тодорхойлж, 23 хүчин зүйлсийг заавал судлахыг чухалчилсан.
2. **EFE** Гадаад хүчин зүйлсийн үнэлгээний матрицаас жинлэгдсэн дундаж оноо 2.54 гарсан нь гадаад орчин боломжтой гэдгийг илтгэж байна.
3. **IFE** Дотоод хүчин зүйлсийн үнэлгээний матрицаас жинлэгдсэн дундаж оноо 2.4 гарсан нь дотоод орчин сул гэдгийг илтгэж байна.
4. **CPM** Өрсөлдөөнийг тодорхойлогч матрицаас Монгол улсын өрсөлдөх чадварын оноо 1.95 байгаа нь хөрш орнуудтай харьцуулахад чадвар муу байгааг харуулж байна. Монгол орны хувьд гол өрсөлдөгч нь Өвөр Монголын Өөртөө засах орон бөгөөд өрсөлдөх чадварын оноо нь 3.07 байна.
5. **SWOT** Давуу тал, Сул тал, Боломж, Аюулыг тодорхойлох матрицаар SO, WO, WT, ST стратегиудад хийгдэх бодлогыг тодорхойлсон.
6. **SPACE** Стратегийн байрлал болон тухайн байгууллагын одоо баримталж буй стратегийг тодорхойлох матрицаас “Хамгаалах стратеги” баримтлан үйл ажиллагаа явуулж байна гэсэн дүгнэлтэд хүрсэн.
7. **BCG** Бостоны зөвлөх группын матрицын хувьд Монгол орны дотогшоо чиглэсэн аялалын өнөөгийн байдал “Асуултын тэмдэг” бүхий байршилд оршиж байна.
8. **IE** Гадаад болон дотоод хүчин зүйлсийн матрицаас үзэхэд үнэлгээний баллын дүнгийн нэгтгэлийн 63 % нь буюу 11 үзүүлэлт Өсөлтийн стратегийн талбарт оногдож байна.
9. **QSPM** Тоон шинжилгээний болон хамгийн боломжит стратегийн хувилбарыг тодорхойлогч матрицаас үзэхэд стратегийн бодлого төлөвлөлтийн дунд хугацаанд WT болон WO стратеги, урт хугацаанд SO болон ST стратегийг баримтлах нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүрсэн болно.
10. **Портерын 5 хүчний шинжилгээ-**гээр өрсөлдөх чадварыг тодорхойлсон бөгөөд олон улсын зах зээлд Монгол орны өрсөлдөөний хүч сул, хөрш орнуудынх их байна гэсэн дүгнэлтэд хүрсэн.

## Дэмжигчдийн судалгаа

Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны эрхэм зорилго нь нийгэм, эдийн засгийн хөгжлийг экосистемийн даацад тохируулан байгаль орчны тэнцлийг хангах, байгалийн баялгийг тогтвортой ашиглах, жам ёсоор нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх замаар ногоон хөгжлийг дэмжиж, тогтвортой хөгжлийг хангах үйл ажиллагаанд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг өрнүүлэх замаар хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад оршино. Байгаль орчин, ногоон хөгжлийн яам нь улс орны тогтвортой хөгжилд нийцсэн байгаль орчин, ногоон хөгжлийн хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөр боловсруулж батлуулах, түүнийг дэмжсэн эрх зүй, эдийн засаг, нийгмийн сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэх, салбарын санхүү, хөрөнгийн удирдлага, зохицуулалтаар хангахад чиглэгдэж байна. Тус яам нь хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулах, байгалийн баялгийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх талаархи хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг олон нийтийн оролцоо, хяналтад тулгуурлан зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, зөвлөгөө өгөх чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Нийслэлийн Аялал жуулчлалын газар нь аялал жуулчлалын талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлогыг Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт хэрэгжүүлж, аялал жуулчлалын хууль тогтоомжийн биелэлтийг хангах, хотын аялал жуулчлалын нөөцийг эргэлтэнд оруулах, аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй хамтарч ажиллах, олон улсын байгууллагын дэмжлэгээр аялал жуулчлал хөгжүүлэх бодлого зохицуулалтыг хэрэгжүүлэх замаар хотын байгаль орчин, эдийн засаг, нийгмийн хөгжилд тухайн салбарын эзлэх байр суурийг нэмэгдүүлэх зорилготой.

Аялал жуулчлалын үндэсний төв аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж байна.

- Үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх
- Монгол Улсын аялал жуулчлалыг нэгдсэн бодлоготойгоор гадаад, дотоодод сурталчлах ажлыг зохион байгуулах
- Монголын аялал жуулчлалын нэгдсэн мэдээллийн санг бий болгож нийтэд вэб сайт, хэвлэмэл хэлбэрээр хүргэх
- Аялал жуулчлалын боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх чиглэлээр төрөлжсөн сургалтууд тогтмол явуулах
- Гадаад, дотоод зах зээлийн судалгаа, шинжилгээг хийж бодлого боловсруулах дээд байгууллагыг мэдээллээр хангах
- Гадаадын хандивлагч нартай хамтран аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх

## Хамтран ажиллагчид:

Аялал Жуулчлалын Үндэсний төв

Монголын Аялал Жуулчлалын Холбоо

Аялал Жуулчлалын Тогтвортой Хөгжлийн Төв

Монголын Газарзүй, Аялал Жуулчлалын Холбоо

Монголын Аялал Жуулчлалын багш судлаачдын нийгэмлэг

Монголын Залуучуудын Аялал Жуулчлалын Холбоо

Төслийн Удирдлага, Хөгжлийн Хүрээлэн

# ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БҮСҮҮДЭД ТУСГАЙ СОНИРХЛЫН АЯЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ДАВУУ ТАЛУУД

## 3.1 Бүсийн зохицуулалт

Бүсчилсэн хөгжлийг төрөөс дэмжих бодлогын гол чиглэл нь Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот, тэдгээрийн орчмын нутгийн хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний хэт бөөгнөрөл, удирдлагын төвлөрөл, экологийн тэнцлийн алдагдлыг сааруулж, бүсүүдийн хөгжлийн түвшинг эрэмбэ дараатай дээшлүүлэх явдал гэж тодорхойлогдсон Бодлогын гол чиглэлийг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэглүүр болгон Монгол Улсад эдийн засгийн Баруун, Хангайн, Төвийн, Зүүн гэсэн дөрвөн бүсийг тогтоож, Улаанбаатар хотыг бие даасан бүсийн жишгээр хөгжүүлэхээр зохицуулагдсан.

Монгол Улсын эдийн засгийн бүс бүрд хамаарах аймгуудын ерөнхий хуваарийг дараахь байдлаар тогтоож, хөгжлийн тухайн үеийн нөхцөл байдалтай уялдуулан уг хуваарийг уян хатан өөрчилж болохоор байна:

a. баруун бүсэд: Баян-өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд
b. хангайн бүсэд: Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл
c. төвийн бүсэд: Говь-Сүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв
d. зүүн бүсэд: Дорнод, Сүхбаатар, Хэнтий.
e. Улаанбаатарын бүсэд: нийслэл хот, түүний дүүргүүдийн нутаг дэвсгэр, хот орчмын бүсийн дагуул хотууд тус тус орно гэж тусгажээ.




Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын зорилтыг хэрэгжүүлэх үе шатыг 2010 оноос хойшхи 10 жилд бүсүүдийн хүрээнд бий болсон бүс нутаг хот байгуулалтын нэгдмэл тогтолцоо, бүс хоорондын болон улс хоорондын аж ахуйн хоршилт, дэд бүтцийн сүлжээнд үндэслэн аймаг, бүс нутгийн аж ахуйн бие даасан байдлыг дээшлүүлэх, бүс нутгийн эдийн засаг, нийгмийн тэнцвэрт хөгжлийг хангах, улмаар үндэсний эдийн засаг, нийгмийн дэвшлийг түргэтгэх нутаг дэвсгэрийн бүтэц, зохион байгуулалтын дотоод, гадаад таатай орчин бүрдэж эхэлнэ.

### 3.2 Аялал жуулчлалын салбарын удирдлага зохион байгуулалт



2012 онд Соёл, Спорт, Аялал жуулчлалын Яам болж шинээр байгуулагдсан нь аялал жуулчлалын салбарыг дотоодод болон гадаадын аялагч жуулчдад илүү хүртээмжтэй байдлаар зохион байгуулахад дөхөм болсон. Манай улсын аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын ерөнхий тогтолцоо нь Соёл, спорт, аялал жуулчлалын яам, Ерөнхий сайдын дэргэдэх Аялал жуулчлалын бодлого зохицуулах Үндэсний зөвлөл, аймаг, нийслэлийн аялал жуулчлалын асуудал хариуцсан нэгжүүд буюу Нийслэлийн аялал жуулчлалын газар, Аймгуудын Байгаль орчин, аялал жуулчлалын газруудаас бүрдэж байна. Аялал жуулчлалын салбарын гадаад харилцаа сүүлийн жилүүдэд өргөжиж арав гаруй улс оронтой хамтран ажиллах Засгийн газар, яамд хоорондын хэлэлцээр байгуулснаас гадна Аялал жуулчлалын мэдээллийн төвийг Улаанбаатар хот, Япон улсын Токио, БНХАУ-ын Бээжин, БНФУ-ын Парис хотуудад байгуулаад байна. Монгол Улс Дэлхийн аялал жуулчлалын байгууллагад 1991 онд гишүүнээр элсэж, бүс нутгийн болон олон улсын аялал жуулчлалын байгууллагуудын үйл ажиллагаанд идэвхитэй оролцдог болов. Монгол орныг гадаадад сурталчилах, гадаадын жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор БНХАУ, БНСУ, ИБУИНВУ, ХБНГУ, Япон зэрэг улсад зохиогддог олон улсын аялал жуулчлалын томоохон үзэсгэлэн яармагуудад тогтмол оролцож байна.

### 3.3 Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын менежментийн чадамж



Судалгаагаар аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын менежментийн чадамжийн үнэлгээний дундаж оноо 54.7 хувьтай буюу “дундаж” үнэлгээтэй гарсан бөгөөд хамт олон болон хэрэглэгчийн үнэлгээний хоорондын нийт зөрүүгээр тооцсон индекс нь 0.50 байна. Хамт олны үнэлгээг индексжүүлэн жигнэсэн дунджаар тооцоход үнэлгээ нь 30.56 хувьтай гарсан бөгөөд индексээр тооцвол 0.56 байна. Хэрэглэгчдийн үнэлгээг индексжүүлэн жигнэсэн дунджаар тооцоход үнэлгээ нь 60.40 хувьтай гарсан бөгөөд индексээр тооцвол 0.39 байна. Чадамжийн шинжилгээгээр хамгийн өндөр үзүүлэлт нь хамт олны хувьд байгууллагын гадаад, дотоод харилцаа, хамтын ажиллагаа сайн гэж үнэлсэн байсан бол хэрэглэгчдийн зүгээс тус байгууллага нөөцийг ашиглах ур чадвар, чадавхи дээгүүр гэж үнэлжээ. Хамт олон хэрэглэгчдээс өгсөн үнэлгээний дунджийг авч үзвэл, тус байгууллагын нөөцийн ашиглалт, чадавхи хангалттай гэж үзсэн.

Менежментийн чадамжийн хамгийн сул үзүүлэлт нь хамт олны хувьд бүтээмж, чанар, гүйцэтгэл хангалтгүй, тус байгууллага дэвшүүлж буй зорилго, зорилтуудаа анхаарах шаардлагатай гэж үзжээ. Судалгаагаар аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын менежментийн чадамжийн үнэлгээний дундаж оноо 54.7 хувьтай буюу “дундаж” үнэлгээтэй гарсан бөгөөд хамт олон болон хэрэглэгчийн үнэлгээний хоорондын нийт зөрүүгээр тооцсон индекс нь 0.50 байна.

1. Зорилго, зорилтын талаархи үнэлгээний дундаж 50.39 хувь байна.
2. Манлайлах чадварыг 53.08 хувь гэж дүгнэлээ.
3. Бүтэц зохион байгуулалтын талаархи үнэлгээ 54.1 байна.
4. Судалгаанаас үзвэл идэвхжүүлэлт, хөшүүргийн талаархи үнэлгээ 52.88 хувьтай байна.
5. Харилцаа, хамтын ажиллагааны талаархи үнэлгээ 59.85 хувьтай байна.
6. Байгууллагын зан үйл, соёлын талаархи үнэлгээ 57.95 хувьтай байна.
7. Нөөц ашиглалт, чадавхийн үнэлгээ 60.21 хувь байна.
8. Мэдлэг, инновацийн талаархи үнэлгээ 51.6 байна.
9. Бүтээмж, чанар, гүйцэтгэлийн талаархи үнэлгээ 52.67 хувьтай байна

### *3.3 Салбарын хөрөнгө оруулалт, дэд бүтэц*



Ìîíãîë óëñàä íèéò 560 òóð îïåðàòîð, 300-ààä çî÷èä áóóäàë ¿éë àæèëëàãààãàà ÿâóóëäàã. Ñ¿¿ëèéí ãóðâàí æèëèéí áàéäëààð æóóë÷äûí òîî 11.0 õóâèàð, àÿëàë æóóë÷ëàëààñ îðñîí îðëîãî 32.5 õóâèàð òóñ òóñ ºñºâ. Ìîíãîë Óëñ çºâõºí 2011 îíä 460.0 îð÷èì ìÿíãàí æóóë÷èí õ¿ëýýí àâ÷, àÿëàë æóóë÷ëàë äîòîîäûí íèéò á¿òýýãäýõ¿¿íèé 4.0 îð÷èì õóâèéã ýçëýõ áîëîâ. Ýíý ñàëáàðò 25.0 ìÿíãà îð÷èì àæëûí áàéð áèé áîëîâ.

Монгол Улсын агаарын тээврийн нийт зорчигч эргэлт 2010 онд 665,803 хүрсэн. Үүнээс олон улсын зорчигч эргэлт 529,000 байсан нь нийт эргэлтийн 79%, харин дотоодын зорчигч эргэлт 137,000 буюу 21%-ийг эзэлж байна. Зам тээврийн салбарт томоохон төсөл хөтөлбөрүүд далайцтай хэрэгжиж эхэлсэн. Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулж аялал жуулчлал, уул уурхайн хөгжлийг хангах чиглэлийг гаргасан.

### Хүний нөөцийн шинжилгээ

Салбарт шууд ба шууд бус утгаар ажиллагсад, хөдөлмөр эрхлэгчдийн тоо нэмэгдсээр байгаа. Àÿëàë æóóë÷ëàëûí ñàëáàð íü áóñàä áèçíåñèéí ñàëáàðûã áîäâîë ñýòãýë ç¿é äýýð òóëãóóðëàí ÿâàãääàã ºâºðìºö ñýòãýë ç¿éí áèçíåñ þì. Ìîíãîë îðîíä ýíý ÷èãëýëèéí ñóäàëãàà øèíæèëãýýíèé á¿òýýë¿¿ä ÷ áóñàä ãàäààä õýëíýýñ îð÷óóëàãäàí óëàì ºðãºæèæ áàéíà. Àÿëàë æóóë÷ëàëûí ÷èãëýëýýð ¿éë àæèëëàãàà ÿðõýëäýã áàéãóóëëàãóóä òóñ ÷èãëýëýýð ìýðãýæèëòýí áýëòãýäýã èõ, äýýä áîëîí ìýðãýæëèéí ñóðãóóëèóäòàé õàìòðàí àæèëëàõ íýí ñîíèðõîëòîé áàéäàã. Ìîíãîë óëñàä ýíý ÷èãëýëýýð ñóäàëãàà øèíæèëãýý õèéæ áóé ìýðãýæèëòýíã¿¿äèéí òîî, óð ÷àäâàð, á¿òýýë òóóðâèë íü ºññººð áàéíà. Аялал жуулчлалын байгууллагууд ÷àäâàðëàã áîëîâñîí õ¿÷íýý òîãòîîõ áàðèõ ¿íäñýí àðãóóäûã èõýýð õýðýãëýäýã áîëîõ íü судалгаанаас õàðàãääàæ áàéãààá ºãºººä àÿëàë æóóë÷ëàëûí ìýðãýæèëòýí óð ÷àäâàð ñàéòàé òîõèîëäîëä àëèâàà àÿëàë æóóë÷ëàëûí ¿éë àæèëëàãààã ýðõýëäýã áàéãóóëëàãàä òîãòâîð ñóóðüøèëòàé àæèëëàí öàëèí õºëñ, íýð õ¿íäýý äýýøë¿¿ëýõ á¿ðýí áîëîìæîî áèé ãýäýã íü òîäîðõîé õàðàãääàæ áàéíà. Ñóäàëãààíä õàìðàãäñàí íèéò îþóòíóóäààñ 35 õóâü íü ýíý ñàëáàð èðýýä¿éòýé ãýæ õàðèóëñàí.

### Баруун бүсийн тусгай сонирхлын аялал жуулчлалын нөөц

1997 онд Дэлхийн шим мандлын нөөц газрын сүлжээнд хамрагдсан Увс нуурын ай савын Дархан цаазат газар, Баян-Өлгий, Ховд, Увс аймгийн Алтай Таван богд, Цамбагарав, Цэнгэл хайрхан, Мөнх хайрхан, Цагаан дэглий, Цагаан шувуут, Түргэний нуруу, Хархираа зэрэг өндөр уулс, Тэс Түргэн, Хархираа, Хангилцаг зэрэг түргэн урсгалт голууд байдаг. 1966 онд ЮНЕСКО-гоос Ховд хотын дэргэдэх Ямаат-Улаан гэдэг нүцгэн улаан буурал уул, Манхан сумын нутаг дахь Хойд Цэнхэрийн агуй, мөн дархан цаазат Отгонтэнгэр уулыг “Дэлхийн гайхамшигт үнэт зүйл болох нь” зэрэглэлээр дэлхийн соёлын өвд бүртгэж авсан байна. Улаангом хотын дэргэдэх Чандмань Улаан уулын археологийн олдвор нь эртний түүх, соёлын нандин өвд зүй ёсоор тооцогддог. Монгол орны үзэсгэлэнт байгаль, баруун Монголын олон ястны амьдрал ахуй зэргийг сонирхуулах өргөн боломжтой. Зэгс, хулсан шагшуурга дунд завиар аялан, ховор жигүүртэн шувууд болон усны амьтдыг үзэх, загасчлах чиглэлээр Увс нуур, мөн Хар-ус нуурын өмнөд эргээр аялал жуулчлалын бааз байгуулах нөөц байна. Ховд аймгийн Хар-ус нуурын хойд эргээр усан спорт хөгжүүлэх боломжтой. Баруун бүсэд түүх-археологийн болон шашин угсаатны зүйн чиглэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх өргөн боломж байна.

| Strength – давуу тал | Weakness – сул тал |
|---|---|

| | |
|---|---|
| ➢ Аялал жуулчлалын нөөц сайн<br>➢ Түүх соёлын нөөц арвин<br>➢ Тусгай хамгаалалтай газрууд их<br>➢ Олон угсаатаны соёл<br>➢ Харилцаа холбоо сайн хөгжсөн<br>➢ Хүний гарт бага өртсөн газартай<br>➢ Монгол орны түүх соёлын дурсгалын үнэт зүйл их<br>➢ Хоёр хөрш орныг холбох боломж өндөр | ➢ Жуулчинд зориулсан үйлчилгээний стандартын байгууллага байхгүй<br>➢ Жуулчидад зориулсан үйлчилгээний газар ховор<br>➢ Жуулчны аюулгүй байдлыг хангах тал дээр тааруу<br>➢ Жуулчинд зориулсан арга хэмжээ зохион байгуулдаггүй<br>➢ Жуулчинд зориулсан бүтээгдэхүүний үнэ харьцангуй өндөр |
| Opportunities-боломж | Threat – аюул |
| ➢ Байгалийн сонин хачин дэлхийд гайхагдах нөөцтэй<br>➢ Аялал жуулчлалын үзмэрийн үнэ цэнэ сайн<br>➢ Жуулчдын аюулгүй байдлыг хангах асуудлыг сайжруулах боломж бий<br>➢ Сурталчилгаа сайн хийвэл жуулчин үзэж харах зүйл арвин<br>➢ Хүний гарт үл өртсөн унаган байгал<br>➢ Нүүдэлчин угсаатны соёлыг харуулсан төв байгуулах боломж их<br>➢ Дэлхийд гайхагдах түүх соёлын үзвэртэй<br>➢ Тусгай хамгаалалттай газар харьцангуй их<br>➢ Байгалийн бүс бүслүүрийг нэг дор харах боломж их<br>➢ Ховор амьтан ургамалын нөөцтэй<br>➢ Нутгийн зон олны соёл нөлөөлөд ороогүй | ➢ Хэрвээ энэ байдлаараа яваад байвал бусад бүсд жуулчин илүү очино<br>➢ Байгаль, угсаатны нөөцөө ашиглан аялал жуулчлалын төвийг барихгүй бол<br>➢ Соёлын үнэт зүйлийг дэлгэн харуулах асуудлыг анхаарахгүй бол бусад орны хуурамч зүйлд хэрэглэгчээ алдана<br>➢ Бүсүүдийн төв, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага хомс |

## Хангайн бүсийн тусгай сонирхлын аялал жуулчлалын нөөц

Цэнгэг устай нуур, байгалийн үзэсгэлэн бүхий Хөвсгөлийн бүсэд усан онгоц, завиар аялах, Үзэсгэлэнт байгаль, ан амьтан, шувуу ажиглах, боломжтой газарт загасчлах, өвлийн улиралд цана, тэшүүр, уулын цанын спортыг хөгжүүлэх, дархад цаатан ардын амьдрал ахуй, зан заншил, соёл, цааны аж ахуйтай танилцуулах чиглэлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой. Монголын түүх, соёлын ховор нандин дурсгал, үзэсгэлэнт байгаль бүхий Орхон голын бүсэд эртний олон овог аймаг, улс гүрний үлдээсэн түүх, соёлын дурсгалт зүйл, хот, балгасын туурь, хөшөө, монголын модон сийлбэрийн урлаг, монголын ард түмний ахуй соёл, зан үйлтэй танилцуулах, Морь, сарлаг унуулах, загасчлах, Рашаан эмчилгээ, сувилгаа хийлгэх, Байгалийн элдэв сонин тогтоц, үзэсгэлэнт газрыг ажиглах чиглэлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой.

| Strength – давуу тал | Weakness – сул тал |
|---|---|
